

1-дүгээр улирал

Нэгж сэдэв	Ээлжит хичээлийн сэдэв	Дасгалын дугаар	Танин мэдэхүйн түвшин		
			Мэдэх	Ойлгох	Хэрэглэх
Уран зохиолын хүүрнэмж эхийн бүтэц	Учир шалтгааны уялдаа	Дасгал 1, алхам 1-4			
	Хүүрнэсэн эхийн бүтэц, дараалал	Дасгал 2, алхам 1-4			
	Богино үлгэр өгүүлэг зохиох	Дасгал 3, алхам 1			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 4, алхам 1-7			
Уран зохиолын хүүрнэмж эхийн утга	Эхийн сэдэв, гол санаа	Дасгал 5, алхам 1-6			
	Үйл явдлын орчин	Дасгал 6, алхам 1-7			
	Сэдэв, гол санаанд тохируулан бичих	Дасгал 7, алхам 1			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 8, алхам 1-11			
Харилцан яриа	Харилцан ярианы үүрэг, цэг тэмдэг	Дасгал 9, алхам 1-6			
	Харилцан яриа зохиох	Дасгал 10, алхам 1			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 11, алхам 1-4			
Жинхэнэ нэр	Жинхэнэ нэрийн утга, бүтэц	Дасгал 12, алхам 1-6			
	Жинхэнэ нэрийн тоо	Дасгал 13, алхам 1-3			
	Жинхэнэ нэрийн тийн ялгал	Дасгал 14, алхам 1-5			
	Жинхэнэ нэрийн хамаатуулах	Дасгал 15, алхам 1-4			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 16, алхам 1-8			
Үйл үгийн утга, бүтэц	Үйл үгийн утга, бүтэц	Дасгал 17, алхам 1-6			
	Нөхцөлдүүлэн холбох нөхцөл	Дасгал 18, алхам 1-3			
	Тодотгон холбох нөхцөл	Дасгал 19, алхам 1-4			
	Цагаар төгсгөх нөхцөл	Дасгал 20, алхам 1-4			
	Биеэр төгсгөх нөхцөл	Дасгал 21, алхам 1-2			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 22, алхам 1-10			

Дасгал ажлын дэвтрийн замын зураглал

2-дугаар улирал

Нэгж сэдэв	Ээлжит хичээлийн сэдэв	Дасгалын дугаар	Танин мэдэхүйн түвшин		
			Мэдэх	Ойлгох	Хэрэглэх
Өдрийн тэмдэглэл	Өдрийн тэмдэглэлийн утга бүтэц	Дасгал 1, Алхам 1-4			
	Бичигчийн сэтгэлийн өнгө аяс	Дасгал 2, Алхам 1-4			
		Дасгал 3, Алхам 1-4			
	Өдрийн тэмдэглэл бичих	Дасгал 4, Алхам 1-3			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 5, Алхам 1-5			
Захидал	Захидлын утга бүтэц	Дасгал 6, Алхам 1-2			
	Захидал бичигчийн санаа	Дасгал 7, Алхам 1-3			
	Захидал бичих	Дасгал 8, Алхам 1			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 9, Алхам 1-5			
Мэдээ, мэдээлэл	Мэдээ, мэдээллийн утга, бүтэц	Дасгал 10, Алхам 1-5			
	Мэдээллийг загварчлах	Дасгал 11, Алхам 1-3			
	Мэдээ, мэдээлэл бичих	Дасгал 12, Алхам 1-2			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 13, Алхам 1-3			
Намтар	Намтрын утга, бүтэц	Дасгал 14, Алхам 1-2			
	Намтрын хэл зүйн онцлог	Дасгал 15, Алхам 1-3			
	Намтар бичих	Дасгал 16, Алхам 1-2			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 17, Алхам 1-4			
Орон цагийн нэр	Орон цагийн нэрийн утга	Дасгал 18, Алхам 1-3			
	Орон цагийн нэрийн хэл зүйн онцлог	Дасгал 19, Алхам 1-3			
	Орон цагийн нэрийн бүтэц	Дасгал 20, Алхам 1-3			
	Орон цагийн нэрийн хэрэглээ	Дасгал 21, Алхам 1			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 22, Алхам 1-4			
Өгүүлбэр	Холбоо үг	Дасгал 23, Алхам 1-5			
	Цөм өгүүлбэр	Дасгал 24, Алхам 1-2			
	Цөм бус өгүүлбэр	Дасгал 25, Алхам 1-5			
	Нэгж хичээлийн үнэлгээ	Дасгал 26, Алхам 1-5			

Үйл явдлын учир шалтгааны уялдаа

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Хүүрнэсэн эхийн үйл явдал: Зохиол эхнээсээ тодорхой дарааллаар өрнөн, өөр хоорондоо хөдөлгөөн харилцаанд орсон тогтолцоог үйл явдал гэнэ. Үйл явдал нь өгүүлбэрээр илэрнэ. Өгүүлбэрт хэдэн үйл үг байна, түүний тоогоор үйл явдал байна. Үйл явдал нь эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл гэсэн өгүүлэгдэхүүн бүтцийн дагуу үргэлжилж, уншигчийн сэтгэлийг хөдөлгөж, цааш унших сонирхлыг төрүүлдэг.

Учир шалтгаан: Юм бүхэн, болж байгаа үйл явдал бүр ямар нэг шалтгааны улмаас үүсдэг. Эхний үйл явдал нь дараагийн үйл явдал бүтэхийн үндэс болно. Ингэж үйл явдлууд өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой болно.

Дасгал 1: Үйл явдлын учир шалтгааны холбоо хамаарлыг задлан шинжлээрэй.

Эцгийн захиас

Эрт урьд цагт гурван хүүтэй нэгэн анчин байжээ. Тэрээр ан гөрөө хийж, аж төрөн суудаг байв.


Анчин насан өндөр, хүчин дорой болж, нэг өдөр утаа гартал татаж тавьдаг увдист шар нумаа их хүүдээ өгч, “Миний гурван хүү тулга хийх нэг нэг чулуу олж ир.” гэжээ. Гурван хүүгийнхээ авчирсан чулууг тулга болгон, гал түлж, тогоо тавиад, цай чанаж эхэлжээ. Дараа нь “Та гурав тус тусын авч ирсэн чулуугаа ав.” гэснийг ёсоор болгохуйд тогоо нь хөмөрч, цай нь асгарч, гал нь унтарчээ.

Тэгсний хойно “ За, миний гурван хүү харав уу? Орчлон гэдэг тогооны ёроол адил бөөрөнхий. Иймээс тулгын гурван чулуу шиг бие биеэ харж, эвтэй явах хэрэгтэй. Хэрэв эвдрэлцэж муудвал энэ хөмөрсөн тогоо, асгарсан цай, унтарсан гал мэт болно.” хэмээн сургамжилжээ.


Алхам 1: Дараах шалтгааны асуултад хариулж бичээрэй.

Асуулт	Хариулт
1. Анчин яагаад их хүүдээ увдист шар нумаа өгсөн бэ?
1. Анчин яах гэж гурван хүүгээрээ тулга хийх чулуу авчруулсан бэ?
1. Юунаас болж тогоо хөмөрч, цай асгарч, гал унтарсан бэ?
1. Юуны учир тулгын гурван чулуу шиг бие биеэ харж, эвтэй яв” гэж сургамжилсан бэ?

Алхам 2: Сэтгэл хөдлөл дээр тулгуурлан, үлгэрийн үйл явдлаас тохирохыг хоосон зайд нөхөж, үйл явдлын өгүүлэгдэхүүн бүтцийг тодорхойлоорой.



Алхам 3: Үйл явдлын учир шалтгааны хамаарлыг тодорхойлохдоо сумаар холбож гүйцээнэ үү.



Алхам 4: Үйл явдлын учир шалтгааны холбоо хамаарлаар ямар санаа илэрхийлснийг тайлбарлаарай.

Тулгын гурван чулуугаар юуг бэлгэдсэн бэ?

Тогоо, цай, галаар юуг төлөөлүүлж ойлгуулсан бэ?

Анчин өвгөний чин хүсэл, захиасны гол санаа юу байсан бэ?

Дууссан:онсарөдөр

Хүүрнэсэн эхийн бүтэц, дараалал

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Эхийн бүтэц гэдэг нь цогцолборуудын хоорондын харилцан уялдааг хэлнэ. Эхийг бүрдүүлэгч өгүүлбэр, цогцолборууд нэг нь нөгөөгөөсөө урган гарч, өмнөх нь дараагийнхаа шалтаан болж уялддаг. Эх нь цогцолборуудаас бүтэх бөгөөд эхлэл, гол, төгсгөл гэсэн 3 хэсэгтэй.

Үйл явдлын дараалал: Хүүрнэсэн эхийн үйл явдал нь тодорхой оронд цагийн дарааллаар өрнөдөг. Үйл явдлын дарааллыг таних үгс нь:

- Өнгөрсөн (өчигдөр, эрт урьд), одоо (өнөөдөр, түрүүхэн), ирээдүй (маргааш, дараа) 3 цагийг заасан утгатай бие даасан үгээр
- Цагийн утгатай холбоо үгээр (агшин зуурт, үдээс хойш)
- Цагийн утгатай өгүүлбэрээр (нар мандах үед, ном унших үед)

Дасгал 2: Эхийн бүтэц, үйл явдлын дарааллыг задлан шинжлээрэй.

Ажиллах эх: Эцгийн захиас (богино үлгэр)

Алхам 1: Дээрх үлгэрт хэдэн өөр хэрэг явдал буюу цогцолбор байна вэ?
Хариултаа тайлбарлаарай.

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4

Алхам 2: Цогцолбор бүр нь эхийн аль хэсэгт хамаарахыг тодорхойлоорой.
Цэгийн оронд тэмдэглэнэ үү.

Үйл явдалд оролцох дүрийн тухай танилцуулсан эхлэл хэсэг

.....


Үйл явдлын орон цаг, зорилго, шалтгааныг харуулсан гол хэсэг

.....

Өмнөх үйл явдлыг нэгтгэж, дүгнэсэн шинжтэй төгсгөл хэсэг

.....

Алхам 3: Өгсөн цаг хугацаанд болсон үйл явдлыг эхээс олж, товч бичээрэй.



Алхам 4: Хүүрнэсэн эхийн үйл явдлын бүтэц, дараалал, учир шалтгааны уялдаа холбооны тухай мэдлэг, ойлголтоо бататгаарай.

- А. Эхийн бүтцийн хэсгийг сумаар зааглаж зураарай.
- Б. Эхийн үйл явдлыг 6 өнгөөр ялгаж харууллаа. Үйл явдал бүр өгүүлэгдэхүүний аль бүтцэд хамаарах вэ? Ижил өнгөөр нь будаарай.

Ертөнцийн үүслийн домог

А.

Эхлэл

Гол

Төгсгөл

Энэ хорвоод эхлээд юу ч байсангүй. Нар, сар, од ч байсангүй. Ертөнц зөвхөн ямар ч хөдөлгөөнгүй түнэр харанхуй хоосон (хаос) байдалтай байжээ.

Түүнээс хамгийн түрүүнд ус бий болжээ. Тэгээд ус нь галыг бүтээж, их халуун болсноор алтан өндөг гарсан гэнэ. Өчнөөн төчнөөн он жилээр хязгааргүй үргэлжилсэн гүн далайд алтан өндөг хөвсөөр, дараа нь хагарав. Ингээд хагарсан өндөгний дээд хэсэг нь тэнгэр, доод хэсэг нь газар шороог бүтээж, тэдгээрийн хоорондох орон зайд агаар мандал үүсэв. Усан дунд газар бий болсноор, гэрлийн орон бүтэж, түүнээс цаг хугацааны эхлэл тавигджээ.

Эцэст нь орчлон ертөнц бүтэв.

Б.

Төгсгөл

Зангилаа


Түйл

Өрнөл

Тайлал

Эхлэл

В. Домгийн үйл явдлын дараалал, учир шалтгааныг цэгийн оронд нөхөж бичээрэй.



Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 3: Өгсөн түлхүүр үгийг ашиглан, үйл явдлыг цагийн дарааллаар, учир шалтгааны уялдаатай өрнүүлж, богино үлгэр зохиогоорой.



Ашиглах түлхүүр үгс

Буга

- Цөөрөм, сүрлэг эвэр, бахархал, нарийн хөл, гомдол
- Арслан
- Айдас, хурд
- Мод, мөчир, эвэр, сандрал тэвдэл
- Амь мэнд, хөл, баяр хөөр

Эхлэл: (Эхлээд хэзээ, хаана юу болов?) -----

Эхийн гол хэсэг

Зангилаа: (Тэгтэл ямар асуудал үүсэв?) -----

Өрнөл: (Тэгээд үйл явдал цааш яаж үргэлжлэв?) -----

Туйл: (Тэгж байтал дахин ямар асуудал хаана үүсэв?) -----

Тайлал: (Үүссэн асуудлууд яаж шийдэгдэв?) -----

Төгсгөл: (Эцэст нь ямар сургамж болов?) -----

Нэгж хичээлийн үнэлгээ

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Илжиг морь хоёр

Эрт цагт нэг хүн илжиг морь хоёртой байжээ. Замаар явж байхдаа илжиг нь моринд:

- “Миний ачаа тун хүнд байна. Би бүгдийг хүргэж чадахгүй нь. Чи миний ачаанаас багахныг ч болов авч хөнгөлж өгөөч” гэхэд морь хайхарсангүй. Илжиг зүтгэсээр байгаад хамаг тамираа барж, үхжээ. Эзэн илжигний бүх ачааг моринд ачиж, бас дээр нь илжигний нойтон арьсыг тохоход нь морь янцаглан:
- “Би гэдэг амьтан ингэж зовлонд баригдах гэж. Хөөрхий би яасан азгүй юм бэ? Түрүүнд түүний ачааг бага ч атугай хөнгөлж өгөх нь яав даа. Одоо бүх ачааг нь ачаад, бас нойтон арьсыг нь тээж явах гэж дээ!” хэмээн гасалжээ.

Дасгал 4: Хүүрнэсэн эхийн бүтцийн тухай мэдлэг, ойлголтоо шалгаарай.



1. Үйл явдлын учир шалтгааныг хамаарлыг харуулсан дээрх тулгуур бичиглэл дээр түшиглэн дараах 3 асуултад хариулаарай.
 1. *Илжиг яагаад үхсэн бэ? Зөв хариултуудыг дугуйлаарай.*
 - A. Морины үл хайхрал
 - B. Эзний өршөөлгүй сэтгэл
 - C. Хүнд ачаа
 - D. Хүч тамир
 2. *Морь юуны учир зовлонд унасан бэ? Зөв хариултуудыг дугуйлаарай.*
 - A. Илжигний үхэл
 - B. Ачаа
 - C. Үл хайхрал
 - D. Хүч тамир
 3. *Дээрх эхэд үйл явдлын учир шалтгааны хамаарлаар ямар санаа илэрч байна вэ?*
 - A. Амьтад эн тэнцүү амьдрах эрхтэй.
 - B. Аминч зан эцэстээ өөртөө зовлон тарина.
 - C. Хэр хэмжээгээ мэдэж хөдөлмөрлөх ёстой.
 - D. Ачааны хүндийг үүрэх нь амь насанд аюултай.

Хүүрнэсэн эхийн сэдэв, гол санаа

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Эхийн сэдэв: Эхэд өгүүлэгдэж байгаа гол юмнаас үүдэлтэй санааг сэдэв гэнэ. Юуны тухай? гэсэн асуултаар илрүүлнэ.

Эхэд дэвшүүлсэн асуудал: Тухайн сэдвийн хүрээнд илэрч буй шийдвэрлэх шаардлагатай асуудлыг хэлнэ.

Эхийн гол санаа: Сэдэв болон дэвшүүлсэн асуудлын хүрээнд гаргасан дүгнэлт санааг хэлнэ.

Түлхүүр үг: Эхэд олон давтагдаж орсон, гарч буй хэрэг явдлын санааг бүтээхэд чухал үүрэгтэй үгийг хэлнэ.

Дасгал 5: Хүүрнэсэн эхийн сэдэв, гол санааг тодорхойлоорой.

Хадат булаг

Хуурай сайрын адагт гурван хайлаас ногоорон хүглийж, түүний хөлд чулуугаар хашиж laidсан бяцхан худаг газрын нүд болон тормойж байдаг байжээ.

Нэгэн удаа эрлийн хүүхэд ирж, амны цангаагаа гарган сууснаа дүрсгүй зан нь гэнэт хөдлөн, худгийн ёроол руу жижигхэн чулуу унагавал “шол” гэснээ сураггүй болжээ.


“Том чулуу шидвэл ямар сүртэй дуугарах бол!” гэж бодон хашлаганых нь бул чулууг арайхийн өнхрүүлж худагт унагавал “пол” гэсэн бөглүү дуу гарснаас өөр дорвитой ч юм болсонгүй. Тэр хүү ямар хэрэг тарьснаа ч ухаарсангүй эрлийн замаа хөөн оджээ.

Болчимгүй зантай хүүгийн бодлогогүй унагасан чулуу худгийн ёроолд унахдаа газрын гүнээс шүүрч байсан булгийн ундаргыг таг даржээ. Удсан ч үгүй худгийн ус ширгэж, хавийн ургамал гуниглан гандаж, саглагар гурван хайлаас хүртэл гиншин хатаж, мөчир нь нүцгэрэн тэнгэрээс хур гуйн сарвайв. Хайлаас дамжин жиргэж байсан богширго нисэн одож, хаа нэгтээ уянгалан байсан дуу эгшиг тасарч, эрэлчин явуулын хүмүүс ч бууж тухлахаа больж, эл хуль болон хоцорчээ.

Хэнэггүй хүний хар гайгаар амьдрал хайрласан булаг хатаж, хадат биш “хадан булаг” болсон нь энэ ажээ.

Н.Өлзийбат, Сэтгэлийн эгшиг, 1991

Алхам 1: Эхэд өгүүлэгдэж байгаа гол юмсыг нэрлэсэн 5 үгийг олоод, тодруулж будаарай.



Алхам 2: Эхийн хэсэг тус бүрд юуны тухай өгүүлснийг харууллаа. Ажиглаад цэгийн оронд өгүүлэгдэж байгаа гол гол юмсыг нөхөж бичнэ үү.

Эхлэл хэсэг	Худаг	Байгалийн унаган төрхийн тухай
Гол хэсэг	Байгалийг сүйтгэгч хүчин зүйлийн тухай
Төгсгөл хэсэг	Байгалийн цөлжилтийн тухай

Алхам 3: Дээрх хүснэгтэд эхийн хэсэг тус бүрд юуны тухай өгүүлснийг харууллаа. Ажиглаад эхийн сэдвийг тодорхойлоод, хариултаа тайлбарлаарай.

- A. Байгалийн тухай
- B. Хүний тухай
- C. Суурьшлын тухай

Алхам 4: Эхийн сэдвээр дамжуулаад, тулгамдсан ямар асуудал дэвшүүлснийг тодорхойлоорой.

- A. Байгалийн тэнцвэр алдагдаж буй тухай
- B. Хүний бодлогогүй, болчимгүй үйл ажиллагааны тухай
- C. Хөдөө нутагт хүний суурьшил багасаж буй тухай

Алхам 5: Эхийн сэдэв, дэвшүүлсэн асуудал, үйл явдлыг сайтар эргэцүүлээд, эхийн гол санааг дүгнээрэй.

- A. Байгалийн тэнцвэр алдагдуулж байгаа гол хүчин зүйл нь хүний буруутай үйл ажиллагаа.
- B. Хүний бодлогогүй болчимгүй үйл ажиллагаа нь өөрийгөө алдагдалд оруулдаг.
- C. Хөдөөд хүний суурьшил багасаж байгаа нь байгалийн дотоод хүчин зүйлтэй холбоотой.

Алхам 6: Эхийн сэдэв, гол санааны тухай мэдлэг ойлголтоо бататгаарай.

Янзагатай согоо

Согоо хөл дээрээ тэнцэж ядан байгаа янзагаа хөхүүлэн зогсоно. Тэр янзагаа үнэрлэнгээ салхины аясаар эвгүй үнэр ирэхийг мэдэрч, чоно ойрхон ирж явааг гадарлав. Гэлээ ч хөл дээрээ тэнцэн ядан байгаа янзагатай согоо хаашаа ч явах билээ дээ... Чоно согоог барихад бэлэн болжээ. Согоо зугтмаар байвч янзагандаа хоргодоод, хаашаа ч хөдөлсөнгүй. Тэр өвчүүн дороо янзагаа зогсоож, өөрийн амиа золиосонд гаргахад бэлэн зогсоно. Чоно дайрах мөчид согоо янзагаа даран урд хоёр хөл дээрээ сөхрөх үед чоно түүний дээгүүр нь харайж, эрчиндээ уналаа. Тэгснээ босон, эргэж ч харалгүй цааш хурдлав.

Өгүүлэгдэж байгаа юм

.....
.....
.....

Сэдэв:

.....
.....

Гол санаа

Үйл явдлын орчин

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Үйл явдлын орчин: Үйл явдал болж байгаа орон газар, цаг хугацааг нийтэд нь орчин гэнэ. Хүүрнэмж эхийн үндсэн шинжийн нэг нь үйл явдал, дүр. Тэгвэл хүүрнэсэн эхийн үйл явдлын орчинд тухайн дүр ямар үг, үйлдэл хийснээс эхийн сэдэв, гол санаа илүү тодорхой болдог. Өөрөөр хэлбэл үйл явдлын орчин нь дүрийн шинж, сэдэв, гол санааг тодруулж өгдөг гэсэн үг.

Дүр: Зохиолын үйл явдлыг дүрслэх явцад бүрэлдсэн хүн, юм, үзэгдэл, бусад хүчин зүйлийг бүхэлд нь дүр гэнэ.

Дасгал 6: Орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлоорой.

Ажиллах эх: Хадат булаг (богино өгүүллэг)

Алхам 1: “Хадат булаг” эхийн гол дүр нь аль вэ? Зөвийг тэмдэглээрэй.



Алхам 2: Үйл явдал хаана? хэзээ? болсныг тодорхойлж, батлан тайлбарлаарай.

Хаана? _____


Хэзээ? _____

Алхам 3: Тухайн оронд, тухайн цаг хугацаанд гол дүрийн хийсэн үйлдлүүдийг жагсаан бичээрэй.

Алхам 4: Хийсэн үйлдлүүдийг ажиглаад, дүрийн шинжийг тодорхойлоорой. Цэгийн оронд тохирох шинжийг эхээс олж бичээрэй.



Алхам 5: Газрын байдал эхэндээ ямар байснаа эцэст нь ямар болж өөрчлөгдсөнийг тодорхойлоорой. Цэгийн оронд тохирох дүрслэлийг эхээс олж бичнэ үү.



Алхам 6: Тухайн газрын дүр төрх өөрчлөгдөхөд хэн буруутай вэ?

- А. эрлийн хүү
- В. чулуу
- С. хур бороо

Алхам 7: “Хадат булаг” эхийн сэдэв, гол санааг эргэн санаарай. Үйл явдлын орчин, зохиолын сэдэв, гол санаа, дүр өөр хоорондоо яаж уялдаж байгааг тайлбарлана уу.

**Сэдэв, гол санаанд тохируулан
үлгэр, өгүүллэг зохиох**

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 7: Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан, богино өгүүллэг зохион бичээрэй.

Сэдэв: Итгэлийн тухай

Гол санаа: Хүнийг чи нэг л удаа хуурах юм бол тэд чамд дахин итгэхгүй.



Үйл явдлын эхлэлийн орчны дүрслэл

.....
.....
.....

Зохиолын эхэнд гол дүрийн байдал

.....
.....
.....

Гэнэт ямар асуудал үүсэв?

.....
.....
.....

Үйл явдал цааш яаж үргэлжлэв?

.....
.....
.....

Байдал хурцдаж, ямар асуудал үүсэв?

.....
.....
.....

Асуудал яаж шийдэгдэв?

.....
.....
.....

Үйл явдал яаж төгссөн бэ? -----

.....
.....

Нэгж хичээлийн үнэлгээ


Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Модон торхтой бал

Баавгай модон торх хийж, зөгийн үүрний дэргэд тавив. Алаг зөгийнүүд эрээн цэцгийн дэлбээн дээр өдөржин бэлчээрлэнэ. Үүрэн сархиагтаа амтат бал боловсруулж, үүрнээсээ зөөж торхонд хийнэ. Баавгай ойгоор тэнэж, торхны модоо аваад ирэхэд л тавьсан торхонд нь амтат бал хийчихсэн байдаг байж. Баавгай амтат балаа идсээр, зун намрыг өнгөрөөж, аглаг хөвч цасанд дарагдав. Баавгай ичээндээ орлоо. Баавгай хэнз яргуйтай уралдан ичээнээсээ гарч, аглаг ой, алаг цэцэгт ургамал, амтат балын эзэн эрээн зөгийнүүдээ эрээд эрээд олсонгүй. Дээрэнгүй эздийн огтолсон хожуул ёрдойно. Баавгай дэргэд нь нулимс дуслуулан зогсоно.

Дасгал 8: Хүүрнэсэн эхийн бүтэц, дарааллын тухай мэдлэг, ойлголтоо бататгаарай.

1. Дээрх эхэд өгүүлэгдэж байгаа гол юмыг олоорой. Цэгийн оронд нөхнө үү.



2. Дээрх эхийн түлхүүр үгийг олоорой.

- A. Баавгай, зөгий, бал, торх, цэцэг, ой,
- B. Баавгай, зөгий, бал, эзэд, хожуул, нулимс
- C. Зун, намар, аглаг хөвч, цас, ичээ
- D. Эрээн цэцэг, цас, хэнз яргуй,

3. Эхийн хэсэг бүрд юуны тухай өгүүлснийг тайлбарлаарай. Харгалзуулна уу.

Эхийн агуулгын бүтэц	Өгүүлэгдэж буй юмс	Өгүүлэгдэж буй юмаар дамжуулан юуны тухай өгүүлэв?
1. Эхлэл хэсэг	1. Хожуул, нулимс	а) Цаг хугацааны урсгал хийгээд баавгайн онцлогийн тухай
2. Гол хэсэг	2. Баавгай, зөгий, бал	б) Байгалийн сүйрлийн тухай
3. Төгсгөл хэсэг	3. Ичээ	с) Байгалийн юмс хэлхээ холбоотой тухай

4. Цогцолбор бүрд юуны тухай өгүүлснийг ажиглаад, эхийн сэдвийг тодорхойлоорой.

- A. Баавгайн тухай
- B. Зөгийн тухай
- C. Байгалийн тухай
- D. Хүний тухай

5. Эхийн сэдвээр дамжуулж ямар гол асуудал дэвшүүлснийг тодорхойлоорой.

- A. Амьтдын тоо толгой цөөрч байгаа тухай
- B. Амьтдын хоол хомс болж байгаа тухай
- C. Байгалийн юмсын гинжин холбоог алдагдуулж байгаа тухай
- D. Хүний мөс чанар муудаж буй тухай

6. Эхийн сэдэв, эхэд дэвшүүлсэн асуудлаар дамжуулж ямар гол санаа илэрч байгааг дүгнээрэй.

- A. Амьтдын тоо толгой цөөрч байгаа нь идэш тэжээлийн хомсдолтой холбоотой.
- B. Амьтдын хоол тэжээл хомс байгаа нь ургамлын гарц муудсанаас болж байна.
- C. Байгалийн юмсын гинжин холбоог алдагдуулж байгаа гол хүчин зүйл нь хүн.
- D. Хүний мөс чанар муудсан нь нийгмийн хөгжилтэй холбоотой.

7. Дээрх эхийн үйл явдал хаана, хэзээ өрнөснийг жишээгээр харуулаарай.

Орон

.....

Цаг

.....

8. Тухайн орчин, (орон цаг)-д гол дүрүүд ямар ямар үйлдэл хийсэн бэ?

Дүрүүд	Баавгай	Зөгий	Хүн
Хийсэн үйлдэл	Ой модыг огтолж, хожуул болгосон.
	
	
	


9. Дүрүүдийн шинжийг тодорхойлоорой.

- Баавгай
- Зөгий
- Хүн

10. Дүрүүдийн үйлдлээр орчин яаж өөрчлөгдсөн бэ?

- A. Байгальд амьтад хор хүргээгүй учир унаган төрхөөрөө байсан.
- B. Байгаль хүний нөлөөгөөр зөгийгүй, цэцэггүй, модгүй болсон.

11. Эхийн агуулгын хэсгүүдийг сумаар холбож, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг тайлбарлаарай.



Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Харилцан яриа: Хоёр болон түүнээс дээш хүний хоорондын яриаг хэлнэ. Харилцан яриа хүүрнэсэн эхэд чухал бөгөөд дүрийн сэтгэл санаа, зан төрх болон тэдний хоорондын харилцааны уур амьсгал, болсон үйл явдлын талаарх мэдээллийг нуршихгүйгээр уншигч, сонсогчдод дамжуулах үүрэгтэй.

Харилцан яриа нь дүр хоорондын шууд яриагаар илрэхээс гадна өгүүлэгчийн болон хэн нэгний дам яриагаар илэрнэ.

Дасгал 9: Харилцан ярианы үүргийг тодорхойлоорой.

А. Тахиа болсон бүргэд

Бүргэдийн зулзага тохиолдлоор тахианы дэгдээхэйнүүдийн дунд унажээ. Тэр тахиа шиг дуугарч, идэх зүйл хайн гүйж, яг дэгдээхэй мэт аашилна.

Нэгэн өдөр тэнгэрт нисэж буй бүргэдийг хараад:

Зулзага: - Ямар гайхалтай шувуу вэ? Хэчнээн өндөрт нисэж байна вэ? Би энэ шувуу шиг нисэж чаддаг сан бол түүн шиг халин дүүлэхсэн.

Дэгдээхэйнүүд: - Бид чинь тахиа шүү дээ. Битгий хоосон мөрөөд. Тэр чинь бүргэд. Чи түүн шиг нисэж чадахгүй.

Бүргэдийн зулзага маш их гуниглажээ. Хэн нэгэн түүнд бүргэд болохыг нь хэлж итгүүлэх хэрэгтэй байлаа. Гэвч түүнд үнэнийг хэлээгүй тул амьдралынхаа төгсгөл хүртэл тахиа шиг амьдарчээ.

Б. Зааны тавилан

Нэгэн аялагч залуу хөдлөх ч үгүй, хол явах ч үгүй нэгэн заантай тааралджээ.

Залуу эзнээс нь "Энэ заанууд яагаад чөлөөтэй явахгүй байгаа юм бэ?" хэмээн асуухад "Зааныг тугал байхаас нь хөлийг нь модтой холбон олсоор уясан юм. Тэд эхэндээ явах гэж оролдсон ч, уяанаасаа зүүгдээд уначихдаг болохоор өөрийгөө хол явж чадахгүй гэдэгтээ насан туршдаа итгэдэг болчихсон юм." гэж хариулжээ.

"Бид эртнээс итгэсэн тэр л зүйлсээсээ болж "Хэзээ ч хийж чадахгүй" хэмээн боддог болчихдог нь үүнтэй л ижил юм даа" гэж залуу аялагч өгүүлжээ.

Алхам 1: Дээрх хоёр эхэд хэн хэн хоорондоо ярилцаж байна вэ?

А. _____

Б. _____

Алхам 2: Дээрх хоёр эхэд харилцан яриа ямар хэлбэрээ өрнөж байна вэ? Зөв харгалзуулаарай.

- Тахиа болсон бүргэд а) Харилцан яриаг өгүүлэгч дамжуулж байна.
- Зааны тавилан в) Дүрүүд шууд харилцан ярилцаж байна.

Алхам 3: Харилцан яриануудыг дахин уншаад, ярилцагч бүрийн зан төрхийг тодорхойлоорой. Зөв харгалзуулна уу.

Дүрүүд	Зан төрх, сэтгэл санаа
1. Бүргэдийн зулзага	а) Сайн сайханд хүрэх гэсэн хүсэлтэй боловч бусдын ятгалгад итгэсэн, сөрөн тэмүүлэх оролдлогогүй, гунигтай
2. Тахианы дэгдээхэйнүүд	б) Нэг зүйлд хатуу итгэчихдэг туйлширмал байдлыг мэддэг, зовнингуй
3. Аялагч залуу	с) Өөрсдийнхөө онцлогийг мэддэг, бусдын чадлыг ч мэддэг, итгэлтэй
4. Зааны эзэн	д) Өөрийнхөө төлөө бусдын эрхийг хязгаарлагч, хэнэггүй

Алхам 4: Дүрүүдийн хоорондын харилцан яриагаар болж буй үйл явдал ойлгогдож байна уу? Дараах хариултаас сонгож, шалтгааныг тайлбарлаарай.

1. Тийм _____
2. Үгүй _____

Алхам 5: Дээрх хоёр эхэд буй харилцан ярианууд нь аль хэв маягт хамаарах вэ? Тайлбарлаарай.

А. _____

Б. _____

Алхам 6: Дараах харилцан ярианд цэг тэмдэг нөхөж бичээрэй.

Харилцан ярианы цэг тэмдгийн тухай ойлголтыг 6-р ангийн сурах бичгээс уншаарай.

... Энэ нутгаас гэнэт алга болоод олон жилийн дараа эргэн ирэхдээ Тулга хамгийн түрүүнд Гүнсмаатай уулзжээ.
 Тулга За, охин минь Чамайг хэний хэн гэдэг вэ
 Охин Дэмбээ гуайн охин Гүнсмаа
 Тулга Аа мөн. Намайг эндээс явахад чи жаахан охин байсан байх аа.
 Охин Тийм ээ. Таныг явах жил би зургаадугаар анги төгсөж ирээд байсан юм.
 Тулга Одоо сургуульдаа юу
 Охин: Үгүй ээ, саальчин болсон
 Тулга Аав ээж нь бий юу
 Охин Гэртээ байгаа
 Тулга “Аав ээждээ намайг ирсэн явна. Амар мэндийг тань айлтгаж байна гэж хэлээрэй” гээд морины жолоо эргүүлэн цааш одлоо...

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 10: Дараах харилцан яриаг үйл явдлаар дэлгэрүүлэн, богино өгүүллэг бичээрэй.

Хайр харуусал

- Ээж минь та яагаад намайг сохолчихсон юм бэ дээ?
- Юм хийж байхад шөвөг авна гээд уйлаад байхаар нь өгчихсөн юм аа.
- Өгөхгүй л байхгүй дээ, ээж минь. Би уйлаад уйлаад ямар сохортлоо уйлав гэж дээ.

Эхлэл: (Дээрх харилцан ярианы гол дүр хаана, хэзээ юу хийж байгаа, дүрийн тухай суурь мэдээллийг дүрслэн бичнэ.)

Зангилаа: (Дээрх харилцан ярианы өмнө юунаас болж ээжтэйгээ энэ тухай ярихаар болж байгааг харуулсан үйл явдал бичих)

Өрнөл: (Дээрх харилцан яриаг бичих) _____

Туйл: (Харилцан ярианы дараа ямар үйл явдал болохыг бичнэ.) _____

Тайлал: (Үүссэн асуудал яаж шийдэгдэж байгааг бичнэ.) _____

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 11: Харилцан ярианы тухай мэдлэг, ойлголтоо шалгаарай.

Тээрэмчин

Охин: - “Аав аа! Түүх дурсгалын бичигтэй сонин чулуу оллоо. Тэр дүгрэг том чулууны ихэнх нь шороонд булагдаад, дөнгөж өнгөн тал нь ил байна. Түүн дээрх бичиг, багшийн ярьж байсан Турк бичиг гэдэг лав мөн байх аа.
 Жолооч: - Таны өсөж төрсөн нутаг ч ёстой диваажингийн орон юм аа? Ингэхэд очих айл маань одоо хол уу?
 Би: - Ойрхон, бараг хонины нь бэлчээрт ирээд байна даа.
 Жолооч: - Урьд шөнө нойр хагастай явсандаа тэр үү, мастер минь дугхиймээр санагдаад байх чинь?
 Охин: - Аав аа! Тэр чулууг очиж үзье л дээ. Тэр бичигний зургийг сайн аваарай. Сургууль цуглахаар багшдаа аваачиж өгнө. Та энэ бичгийг уншиж чадахгүй юм уу?
 Аав: - Охин минь! Энэ чинь түүхийн дурсгал биш зүгээр л тээрмийн чулуу байна шүү дээ.
 Охин: - Тээрмийн чулуу?

1. *Энд охин, аав, жолооч гурвын хооронд яриа өрнөж байна. Эдгээр харилцан яриа нь ямар хэв шинжид хамаарах вэ? Тайлбарлаарай.*

- A. Шууд яриа
- B. Шууд бус яриа
- C. Шууд, шууд бус хосолсон.....

2. *Дүр тус бүрийн яриагаар ямар зан төрх харагдаж байна вэ?*

Жолооч	Аав	Охин
Сайхныг харах нүдтэй Хол замд аяншиж, ядарсан ...		

3. *Энэ 3 хүний яриа дээр тулгуурлан, болж байгаа үйл явдлыг бичээрэй.*

.....

4. *Охин, аав хоёрын яриаг үргэлжлүүлэн зохиогоорой. Тэгэхдээ харилцан ярианы цэг тэмдгийг зөв хэрэглэнэ үү.*

Аав: -

Охин

Аав: -

Охин

Жинхэнэ нэрийн утга, бүтэц

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Хүүрнэсэн эхийн үйл явдал: Үйл явдал нь хүн, юм түүний хөдлөлөөс бүтсэн өгүүлбэрээр илэрнэ. Үүний хүн, юм гэдэг нь жинхэнэ нэрээр, хөдөлгөөн нь үйл үгээр илэрнэ. Жинхэнэ нэр нь хүүрнэсэн эхэд өгүүлэгдэж байгаа юм болон түлхүүр үгийн үүргээр хэрэглэгдэнэ.

Жинхэнэ нэр: Хүн, юм, үзэгдлийг заан нэрлэж, хэн? юу? хэний? юуны? хэнд? юунд зэрэг асуултад хариулагдах үгсийг хэлнэ. Жинхэнэ нэрийг утгаар нь оноосон ба ерийн гэж бас ангилна. Оноосон нэрийг ямагт томоор эхэлж бичнэ.

Дасгал 12: Уншсан эхээс жинхэнэ нэрийг ялгаж, найруулгын үүргийг тодорхойлоорой

Монгол хэлний үгийн аймаг, түүний ангиллыг 6-р ангийн сурах бичгийн 14-р хуудаснаас, жинхэнэ нэрийн утгын тухай онолын ойлголтыг 15-16-р хуудаснаас уншиж, жишээг сайтар ажиглаж, ойлгоорой.



Гэр
(үлгэрийн гол хэсэг)

Эрт цагт ухаанаас өөр өв хөрөнгөгүй нэгэн өвгөн амьдарч байжээ.


Нэгэн өдөр өвгөн долоон хүүдээ "Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно." гэж ярихад хөвгүүд нь учрыг олсонгүй өнгөрчээ. Өвгөн хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг нарнаас тооно, тал тал тийш урссан алтан цацрагуудаас унь, уулын араас

ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. "Түшилдэн ханхайсан уул нуруунуудын араар хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа." гэж бодуутаа хялгас томж, бүслүүр хийв. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож, тооноо өргөж, униа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад, бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.

Нүүе гэвэл эвхээд ч уядаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр бүтээсэн эцгийнхээ ухааныг хөвгүүд нь биширч, ая тавтай аж төрөх болжээ.

Алхам 1 : Дээрх хүүрнэсэн эхэд өгүүлэгдэж буй юмыг заан нэрлэж буй үгийг түүж бичээрэй.


Алхам 2: Дээрх эхэд тодруулсан жинхэнэ нэрийн жишээнд харгалзах утгыг өнгөөр хүрээлж будаарай.



Алхам 3: Ангилал тус бүрд хамаарах үес аль асуултад хариулагдахыг тайлбарлаарай.

- A. Хэн?
- B. Юу?

Алхам 4: Бүдүүвч дэх ерийн нэрийн өмнө оноосон нэр бичээд, дүрмийг тайлбарлаарай.



Алхам 4: Дээрх эхэд тодруулсан зарим үгийг үүсмэл ба үүсмэл бишээр нь ялгаж харууллаа. Жишээг ажиглаж, ялгааг ойлгоорой. Үүсмэл жинхэнэ нэрийг язгуур, дагавраар зааглаж бичээрэй.

Жинхэнэ нэр бүтэх ёс		
Үүсмэл		Үүсмэл биш
Дагаврын аргаар бүтсэн (Үгийн язгуур үндсэнд дагавар залгаж бүтнэ.)	Үг нийлэх аргаар бүтсэн (Хоёр өөр үг нийлж 1 юмыг нэрлэнэ.)	өвгөн гэр дэлхий
ухаан = ух+аан	өв хөрөнгө	хүү
шуурга =	эргэн тойрон	үлгэр
цацраг =	манан будан	учир
дээвэр =	уул нуруу	уул

Алхам 5: Дараах өгүүлбэрт өгүүлэгдэж байгаа юмсыг заасан жинхэнэ нэр ямар үгтэй холбогдож байгааг тодорхойлоорой.

Тэгээд **өвгөн** долоон **хүүтэйгээ ханаа** дэлгэж, **хаалгаа** босгож, **тооноо** өргөж, **униа** өлгөж, **туургаа** барьж, **дээврээ** тавьж, **бүслүүрээ** татаад, бөмбөрцөг **дэлхийн хэлбэртэй** бөмбөгөр цагаан **гэртэй** болов гэнэ.

Алхам 6: Жинхэнэ нэрийн найруулгын үүргийг тайлбарлаарай. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхөж гүйцээгээрэй.

Хүүрнэсэн эхийн гол шинж нь Үйл явдал нь юмыг заасан буюу, үйлдэл хөдөлгөөн заасан буюу үгийн хослол бүхий өгүүлбэрээр илэрнэ. Тиймээс жинхэнэ нэр нь хүүрнэсэн эхийн утгыг бүтээхэд өгүүлэгдэж байгаа юмсыг заан нэрлэж, үйл үгтэй холбогдон, өгүүлбэр буюу үйл явдлыг бүтээж байна.

Жинхэнэ нэрийн олон тоо

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Үгийн бүтэц: Монгол хэл бол залгамал бүтэцтэй. Тиймээс үгийн бүтэц нь язгуур+ үг бүтээх дагавар+ нөхцөл гэсэн дараалалтай байна. Тиймээс жинхэнэ нэр нь язгуур+ **тоо+ тийн ялгал+ хамаатуулах** гэсэн бүтцийн дараалалтай байдаг.

Олон тооны дагавар: Хүн, юмны ерөнхий олныг илтгэх утгатай бүтээврийг хэлнэ.

Дасгал 13: Олон тооны дагаврын хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Алхам 1: “Гэр” үлгэрээс ерөнхий олны утгатай үгсийг түүж бичээд, бүтцээр задлаарай.

Олон тооны дагаврууд:
-ууд, -үүд, -чууд, -чүүд,
-д, -с, -нар,

хөвгүүнд, уул+с,
.....

Алхам 2: Олон тооны нөхцөлийг найруулгад зөв хэрэглэх тухай тайлбарыг уншаад, жишээг зөв болгож засаарай.

<p>1. Өмнөө тооны нэр болон ерөнхий олны утгатай үг авсан жинхэнэ нэр олон тооны нөхцөлөөр хувилахгүй.</p>	<p>а) Зарим оюутнууд хичээлээ сонгоно. Гучаад сурагчид суралцана.</p>	<p>.....</p>
<p>2. Өгүүлэхүүн нь бэлч, тарх, бөөгнө, барилд, уралд, багшир гэх мэт үйл үгээр илэрсэн байвал үйлийн эзэн болж байгаа жинхэнэ нэр олон тооны нөхцөл авахгүй.</p>	<p>а) Малууд бэлчинэ. Бөхчүүд барилдана.</p>	<p>.....</p>
<p>3. Нэг үгэнд олон тооны нөхцөлийг давхарлан залгахгүй.</p>	<p>а) Бид нар хичээлдээ явна.</p>	<p>.....</p>
<p>4. Тодруулсан үгийг давтсан тохиолдолд олон тооны нөхцөлөөр хувилахгүй.</p>	<p>а) Өндөр өндөр уулс, өргөн өргөн голуудыг гатална.</p>	<p>.....</p>

Алхам 3: Дараах үгсийг ажиглаад, олон тооны нөхцөлөөр хувилгаж болох эсэхийг тайлбарлаарай.

гурил, будаа, цас, элс, шороо
нар, сар, дэлхий, алтан гадас
хөдөөнийхөн, ахынхан, багачууд

Дууссан:онсарөдөр

Жинхэнэ нэрийн тийн ялгал

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Тийн ялгалын нөхцөл: Жинхэнэ нэрийг бусад үгтэй холбох үүрэгтэй бүтээврийг хэлнэ. Тийн ялгал нь бодит ертөнцийн юм үзэгдэл, шинж чанар, үйл хөдлөлийн хоорондох харьцаа буюу өгүүлбэрийн бүтэц дэх жинхэнэ нэрийг бусад үгтэй төрөл бүрийн утгаар холбох үүрэгтэй. Тийм учраас үзүүлэх утгаас нь хамаарч нэрлэх, харьяалах, өгөх орших, заах, гарах, үйлдэх, хамтрах, чиглэх гэсэн 8 тийн ялгал болгон ангилдаг.

Дасгал 14: Жинхэнэ нэрийн тийн ялгалын хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Ажиллах эх: Гэр (үлгэрийн гол хэсэг)

Алхам 1: Дараах асуултад хариулж бичээрэй. Загварыг гүйцээнэ үү.

- Хэн? Өвгөн яав? амьдарч байв.
- Хэн? _____ юунаас? уулсаас _____ юуг? хана яав? хийх санаа олов.



- _____ юуг? _____ яав?
- _____ юуг? _____ яав?
- _____ юуг? _____ яав?
- _____ юуг? _____ яав?
- _____ юуг? _____ яав?

- Хэн? _____ хэнтэй? _____ юуг? _____ яав?



- _____ юуг? _____ яав?
- _____ юуг? _____ яав?
- _____ юуг? _____ яав?
- _____ юуг? _____ яав?
- _____ юуг? _____ яав?

- Хэн? _____ хэний? _____ юуг? _____ яав?

Алхам 2: Дараах жинхэнэ нэрийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаж, дүрмийг тайлбарлаарай.

Тийн ялгалын нэр	Г-ээр төгссөн эр үг	Гээгдэх эгшигтэй үг	Б-ээр төгссөн үг	Гээгдэхгүй эгшгийн дүрэм
Нэрлэх	цацраг	дээвэр	унь	үлгэр
Харьяалах				
Өгөх орших				
Заах				
Гарах				

Үйлдэх				
Хамтрах				
Чиглэх				
Зөв бичих дүрэм тайлбарлах				

Алхам 3: Дээрх үлгэрт тийн ялгалын тохирох нөхцөлийг нөхөж бичээд, үлгэрийг цааш үргэлжлүүлэн уншаарай.

Гэр (гол хэсгийн үргэлжлэл)

Үлгэр... ингээд дууссангүй ээ. Өвгөн аав... нь нэг өдөр хэвтэр... орж, хөвгүүд...ээ “Төрөх нэг өдөр байхад, төгсөх нэг өдөр бий. Ханан гэр...ээ аав... нь хадан гэр...ээ буцах боллоо” гэжээ. Яаж аж төрөхийг гэр... чинь заагаад өгнө. Гагцхүү гэр... бүслүүр...ээ л чангалж яваарай.” гэжээ. Хөвгүүд... нь мөн л урьдын адил учир... ололгүй хоцорчээ...

Зөвлөмж: Дараах харилцан яриаг уншаад, нэрлэхийн тийн ялгалын тухай илүү сайн ойлгож аваарай.

А: - Нэрлэхийн тийн ялгал нөхцөлтэй юу?

Б: - Нөхцөлтэй.

А: - Ямар?

Б: - Тэг нөхцөлтэй.

А: - Яаж таних вэ? Бас яаж тэмдэглэх вэ?

Б: - Асуултаар нь танина. Нэрлэхийн тийн ялгал нь хэн, юу гэсэн асуултад хариулагдана. Бас утгаар нь таньж болно. Өгүүлбэрт тухайн үйлийг хийсэн эзний утга зааж байгаа жинхэнэ нэр нэрлэхийн ялгалд байна. Харин тэмдэглэхдээ болно.

Алхам 4: Дараах өгүүлбэрт байгаа жинхэнэ нэр ямар тийн ялгалын нөхцөлөөр нөгөө үгтэй холбогдож байгааг тодруулаарай.

Тэгтэл нэг өдөр гэрийн бүслүүр нь суларч, яйжийж унав гэнэ. Ингээд ах дүү долоо эцгээс үлдсэн хөрөнгийг эн тэнцүү хувааж авахаар шийдээд, хана, унь, хаалга, тооно, дээвэр туургаа салган үүрч, харсан зүг рүүгээ одоцгоов.

Алхам 5: Тийн ялгалын нөхцөлийн утга, найруулгын үүргийн тухай дараах тайлбарыг гүйцээгээрэй.

Жинхэнэ нэр нь нэрлэх, өгөх орших,,,, хамтрах, тийн ялгалын нөхцөлөөр үйл үгтэй холбогдож, хүүрнэсэн эхийн үйл явдлыг бүтээнэ. Харин тийн ялгалын нөхцөл нь жинхэнэ нэрийг жинхэнэ нэртэй холбож, тухайн хүн, юм хэний, юуны харьяалалд байгааг тодотгох үүрэгтэй.

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Хамаатуулах нөхцөл: Тухайн хүн, амьтан, юмс үзэгдлийг төрлийнх нь олон юмны дотроос ялгахын зэрэгцээгээр хэнд, юунд хамаатай болохыг жинхэнэ нэрийн хамаатуулах ёс гэнэ. Хамаатуулах нөхцөлийг биед хамаатуулах, эзэнд хамаатуулах гэж хоёр ангилна. Эзэнд хамаатуулах нь –аа, -ээ, -оо, -өө нөхцөлөөр, биед хамаатуулах нь минь, маань, (1-р бие), чинь, тань (2-р бие), нь (3-р бие) нөхцөлөөр тус тус илэрнэ.

Дасгал 15: Жинхэнэ нэрийн хамаатуулах нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Хөвсгөл далай (өгүүллэгийн хэсгээс)

Би Хөвсгөл далай ээжийнхээ торгон эрэг дээр зогсож байна. Их давлагаан ирж, санаа алдах мэт болоод чимээ тасарна. Далай минь, бүлээхэн тунгалаг ус чинь нялх багын минь нулимсыг санагдуулах чинь юу билээ. Эрх багын гомдол баярын нулимсаа энд унагаасан юм биш байгаа. Элэг дотно энэ их ус чинь ч гэсэн эцэг өвгөдийн минь нулимс биш байгаа. Эдүгээ бид чинь “Эрдэнэ болсон далай ижий минь” гэж энхрий хайрын нулимсаа унагахыг больсон юм биш байгаа...

Алхам 1: Дээрх эхэд байгаа хамаатуулах нөхцөлтэй үгсийг ангилаарай.

Эзэнд хамаатуулах нөхцөлтэй үг

.....

Биед хамаатуулах нөхцөлтэй үг

.....

Алхам 2: Хамаатуулах нөхцөлтэй үгс нь утгаараа хэнийх, юуных болохыг тодорхойлоорой. Цэгийн оронд бичнэ үү.

Би (надад)	Далай ээжид	Бидэнд
далай ээжийнхээ		нулимсаа

Алхам 4: Дараах үгсийг тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр хувилгана уу. Ямар тийн ялгалтай үг эзэнд хамаатуулах нөхцөлөөр хувилдаггүйг олоорой.

Нэрлэх		
Харьяалах		ээжийнхээ
Өгөх орших		
Заах		
Гарах		
Үйлдэх	хайраараа	
Хамтрах		
Чиглэх		

Дууссан:онсарөдөр

Нэгж хичээлийн үнэлгээ

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Хамаатуулах нөхцөл: Тухайн хүн, амьтан, юмс үзэгдлийг төрлийнх нь олон юмны дотроос ялгахын зэрэгцээгээр хэнд, юунд хамаатай болохыг жинхэнэ нэрийн хамаатуулах ёс гэнэ. Хамаатуулах нөхцөлийг биед хамаатуулах, эзэнд хамаатуулах гэж хоёр ангилна. Эзэнд хамаатуулах нь –аа, –ээ, –оо, –өө нөхцөлөөр, биед хамаатуулах нь минь, маань, (1-р бие), чинь, тань (2-р бие), нь (3-р бие) нөхцөлөөр тус тус илэрнэ.

Дасгал 16: Жинхэнэ нэрийн тухай мэдлэг, ойлголтоо шалгаарай**Үхэр хулгана**

Хоёр үхэр хулгана өндөг олжээ.

“Түүнийг идэх сэн” гэж хүсэвч өндгийг булаах гэсэн хэрээнүүд нисээд амраадаггүй.

“Явал өндгийг хэрээнүүдэд алдчихгүй байх вэ?” гэж тэд боджээ. Зөөө гэхээр хүч нь хүрдэггүй, өнхрүүлье гэвэл хагарчаж мэднэ. Үхэр хулганууд ухаанаа зарж, ингэж шийджээ.

Нэг нь дээшээ харж хэвтээд өндгийг тал талаас нь хөлөөрөө тулахад нөгөөх нь түүний сүүлнээс чарга чирч яваа юм шиг угзарсаар өндгийг шалан доогуур авч оржээ.

1. *Дээрх эхээс жинхэнэ нэрийг түүж бичээд, асуулт тавиарай.*

.....

2. *Түүсэн жинхэнэ нэрүүд ямар утгатайг тайлбарлаарай.*

- A. Ерийн нэр
- B. Оноосон нэр

3. *Үүсмэл жинхэнэ нэрийг олж, бүтцээр задлаарай.*

- A. Өндөг
- B. хэрээ
- C. ухаан
- D. сүүл

4. *Дээрх эхээс олон тооны дагавартай үгийг олж бичээрэй. (.....)*5. *Дээрх эхэд ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ? (.....)*6. *Дээрх эхэд байгаа хамаатуулах нөхцөлтэй үгийг түүж, бүлэглэнэ үү.*

- Эзэнд хамаатуулах нөхцөлтэй үг
- Биед хамаатуулах нөхцөлтэй үг

7. *Дараах жинхэнэ нэрийг үгийн бүтцээр задлаарай.*

- хөлөөрөө
- сүүлнээс

8. *Дээрх жинхэнэ нэрүүд хүүрнэсэн эхийн утга агуулгыг бүрдүүлэхэд ямар үүрэгтэй байна вэ?*

- A. Өгүүлэгдэж байгаа юм
- B. Эхийн бүтэц
- C. Дэвшүүлсэн асуудал
- D. Орчин


Үйл үгийн утга, бүтэц

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Үйл үг: Хүн, юм, үзэгдлийн үйл хөдлөл, явц, байдлыг зааж, яав? яалаа? яасан? яаж?...гэх мэт “яа-“ язгууртай асуултад хариулагдах үгсийг үйл үг гэнэ. Үйл үгийн тоогоор үйл явдал бүтнэ. Үйл үгийг утгаар нь тусах, эс тусах гэж ангилна. Өмнөө заахын тийн ялгалын нөхцөлтэй нэр үгийг захирч чадах үйл үг нь тусах, захирч чадахгүй байвал эс тусах үйл үг болно.

Дасгал 17: Үйл үгийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.



Гэр

(Үлгэрийн төгсгөл)

...Ууган хүү нэгэн газар хүрч, хаалгаа босгон, хэрүүл уруулгүй амар жимэр сууж байтал өдөржин хурц нар төөнөөд, арай л шатаачихсангүй. Удаах хүү сараалжин ханаа дэлгээд, унтаж хэвттэл гэнэт ширүүн бороо асгаж, аянга эгээтэй л ниргэчихсэнгүй. Дараах хүү туургаа авч, хоргодон суутал, уулын үер урсгаад явчих шахав. Бас нэг нь дээврээ авч, дор нь амарч хэвттэл хуй салхи босож, хуу татаад хаяж гэнэ. Нөгөө нь толгой дээрээ

тооноо өргөөд сууж байтал шөнө болж, араатан чоно тал талд нь архиралдаж гэнэ. Униа боож, шовойлгон хоргодож суусан нэгийг хүйтэн жавар хайрч, хөлдүүс болгох дөхөв. Бага хүүд бүслүүрээс өөр юм үлдээгүй тул бүр ч хэцүү байжээ.

Тэгтэл нэг өдөр түүн дээр хана үүрсэн ах нь буцаад иржээ. Удаах ах нар нь удалгүй хаалга, тооно, унь, дээвэр, туургаа үүрсээр, ар араасаа цувран айсуй. Тийнхүү долоон хүү буурал эцгийнхээ гэрээс үгийн учрыг сая л ухаарч, түүнээс хойш үеийн үед өргөө цагаан гэрээ эвийн сүлд болгон дээдлэн хүндэлсээр амар сайхандаа жаргажээ.

Алхам 1: Дээрх эхээс яав, яаж, яатал? гэх мэт асуултад хариулагдах үгийг цэгийн оронд нөхөж бичээрэй.


Хэн ?	Юуг?	1. Яав?	2. Яав?	Юу?	Хэнийг	3. Яав?	4. Яав?
ууган хүү	хаал-гаа	босгон	сууж байтал	нар	хүүг шатаачихсангүй	
удаах хүү	ханаа	унтаж хэвттэл	бороо аянга	хүүг	ниргэчихсэнгүй
дараах хүү	туургаа	авч,	үер	хүүг	урсгаад явчих шахав.	
бас нэг нь	дээврээ	авч	хуй салхи	дээврийг	босож
нөгөө нэг	тооноо	сууж байтал	чоно			архиралдав
өөр нэг нь	униа	боож шовойлгон	жавар	хүүг, хөлдүүс болгох шахав.	
отгон хүү		хэцүү байв.					

Алхам 2: Яав? гэсэн асуултад хариулагдаж буй үгс ямар утгыг зааж байна вэ? Т3

Тайлбарлаарай.

- A. Үйлдэл, хөдөлгөөн
- B. Хүн, юм, үзэгдэл
- C. Шинж чанар

Алхам 3: Дээрх хүснэгтээс яав? гэсэн асуулт бүхий эгнээг ажиглаарай. Аль дугаарт тусгах, алинд нь эс тусгах үйл үг байгааг доор тэмдэглээрэй.



Алхам 4: Налуугаар бичсэн төгсгөлийн цогцолбор дахь үйл үгийг үүсмэл, үүсмэл бишээр нь ангилан бичлээ. Үүсмэл үгийг бүтцээр зааглана уу.

Үйл үг бүтэх ёс		
Үүсмэл		Үүсмэл биш
Дагаврын аргаар бүтсэн (Үгийн язгуур үндсэнд дагавар залгаж бүтнэ.)	Үг нийлэх аргаар бүтсэн (Хоёр өөр үг нийлж 1 юмыг нэрлэнэ.)	жарга буц ир үүр
цувар=	дээдлэн хүндлэх	
ухаар =		
дээдэл =		

Алхам 5: Үйл үгийн тоогоор үйл явдал байна. Тэгвэл өгүүлбэр бүрд хэдэн үйл явдал дүрслэгдсэнийг олоорой.

Хэн ?	Юуг?	1. Яав?	2. Яав?	Үйл явдлын тоо
Ууган хүү	хаалгаа	босгон	сууж байтал	2
Удаах хүү	ханаа	дэлгээд,	унтаж хэвттэл	
Дараах хүү	туургаа	авч,	хоргодон суутал	
Бас нэг нь	дээврээ	авч	амарч хэвттэл	
Нөгөө нэг	тооноо	өргөөд,	сууж байтал	
Өөр нэг нь	униа	боож шовойлгон	хоргодож суутал	
Отгон хүү		хэцүү байв.		1

Алхам 6: Үйл үгийн хүүрнэсэн эхэд гүйцэтгэх найруулгын үүргийг тайлбарлаарай. Дараах тайлбарыг гүйцээнэ үү.

Үйл явдал нь юм, түүний хөдөлгөөнөөс бүтнэ. Үүний юм нь жинхэнэ нэрээр, хөдөлгөөн нь илэрнэ. Өөрөөр хэлбэл хүүрнэсэн эхийн хамгийн гол шинж болох үйл явдлыг бүтээдэг хамгийн гол хоёр үгийн аймаг бол жинхэнэ нэр, хоёр юм. Үйл үг нь холбох болон төгсгөх нөхцөлөөр хувилж, орон, цаг, зорилго, шалтгаан, шинж байдал зэрэг төрөл бүрийн нэмэлт утга, өнгө аясыг бүтээнэ.

Дууссан:онсарөдөр

Үйл үгийн нөхцөлдүүлэн холбох нөхцөл

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Үйлийн холбох нөхцөл: Холбоо үг, өгүүлбэрийн бүтцэд орсон үйл үгийг бусад үйл үг болон нэр үгтэй холбох үүрэгтэй нөхцөлүүдийг үйлийн холбох нөхцөл гэнэ. Үйлийн холбох нөхцөлийг нөхцөлдүүлэн холбох, тодотгон холбох нөхцөл гэж хоёр ангилна.

Нөхцөлдүүлэн холбох нөхцөл: Үйл үндсийн дараа орж, тухайн үйл үгийг бусад үйл үгтэй холбох үүрэгтэй нөхцөлийг хэлнэ.

Дасгал 18: Уншсан эхэд хэрэглэсэн үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Ажиллах эх: Гэр (үлгэрийн төгсгөл)

Алхам 1: Нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үйл үгсийг эхээс түүж бичээд, 2, 2 үгийг бүтцээр задлаарай.

Нөхцөл	Жишээ	Бүтцээр задлах
- ж, -ч		
- н		
- саар 4		
- н		
- тал4		

Эдгээр (вал⁴ –бал⁴, -магц⁴, - вч, - хлаар⁴, -нгуут, -нгүүт, - нгаа⁴, -лгүй) нөхцөл нь нөхцөлдүүлэн холбохын нөхцөл. Ийм нөхцөлтэй үйл үг дээрх эхэд байхгүй байна.

Алхам 2: Дараах үгс өгүүлбэрт ямар үгтэй холбогдож байгааг олж бичээрэй.

ухаарч
 өргөөд
 босгон
 үүрсээр
 суутал

Алхам 3: Нөхцөлдүүлэн холбох нөхцөлүүд нь нэг үйл үгийг нөгөө үйл үгтэй холбохдоо ямар ямар утгыг илэрхийлж байгааг жишээгээр тайлбарлаарай.

- A. Үйл явдлууд зэрэгцэж болж байгааг
- B. Үйл явдлууд дараалан болж байгааг.....
- C. Үйл явдлууд үргэлжилж байгааг
- D. Үйл явдлууд эсрэгцэж байгааг
- E. Үйл явдлын шалтгааныг (ухаарч дээдлэн хүндлэх болсон.) *Тэгэхээр –ч нөхцөлөөр дээдлэн хүндлэх болсны шалтгааны утгыг илэрхийлж, холбосон байна.*

Үйл үгийн тодотгон холбох нөхцөл

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Тодотгон холбох нөхцөл: Үйл үндсийн дараа орж, тухайн үйл үгээ дараагийн нэр үгэнд холбох үүрэгтэй нөхцөлийг хэлнэ. Эдгээр нөхцөлүүд нь өнгөрсөн, одоо, ирээдүй 3 цагийг ялган заана.

Дасгал 19: Уншсан эхэд хэрэглэсэн үйлийн тодотгон холбох нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Ажиллах эх: Гэр (үлгэрийн гол хэсэг)

Алхам 1: “Гэр” эхээс дараах нөхцөлтэй үйл үгсийг түүж, утгаар нь бүлэглэн бичээрэй.

Нөхцөлийн утга	Нөхцөл	Жишээ үг
Өнгөрсөн цаг	-сан, -сэн, -сон, -сөн	хүрээлсэн,
Одоо цаг	-аа, -ээ, -оо, -өө, -даг, -дэг, -дог, -дөг	нээгддэг,
Ирээдүй цаг	-х, -маар, -мээр, -моор, -мөөр	

Алхам 2: Түүсэн үгсээ бүтцээр задлаарай.

Алхам 3: Тодтогон холбох нөхцөлтэй үгс нь өгүүлбэрт ямар аймгийн үгтэй холбогдож, тухайн юмны шинжийг тодруулж байгааг олоорой.

Өвгөн хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг нарнаас тооно, тал тал тийш урссан алтан цацрагуудаас унь, уулын араас ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. Түшилдэн ханхайсан уул нуруунуудын араар хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа гэж бодуутаа хялгас томж, бүслүүр хийв.

Алхам 4: Үйл үгийн найруулгын үүргийн тухай дараах тайлбарыг тэмдэглээрэй.

Тодотгон холбох нөхцөл нь үйл үгийг нэр үгтэй холбоно. Тийм учраас жинхэнэ нэрийн нөхцөлөөр (сууснаараа, бодохоосоо) хувилна. Тодотгон холбох нөхцөл нь хүн, юм, үзэгдлийг заасан нэр үгийг үйл явдлын цаг болоод шинжээр тодотгон, дүрслэх үүргээр хүүрнэсэн эхийн найруулгад хэрэглэгддэг.

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Төгсгөх нөхцөл: Өгүүлэгчийн хандлагыг илэрхийлж, өгүүлбэр төгсгөдөг нөхцөлүүдийг хэлнэ. Үйл үгийн төгсгөх нөхцөлийг цагаар төгсгөх, биеэр төгсгөх гэж 2 ангилна.

Цагаар төгсгөх нөхцөл: Өгүүлэгчийн үйлийг хэрхэн үнэлж байгаа хандлагыг заадаг, өнгөрсөн, одоо, ирээдүй 3 цагийн утга илтгэх нөхцөлийг хэлнэ.

Дасгал 20: Үйл үгийн цагаар төгсгөх нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Ажиллах эх: Гэр (үлгэрийн гол ба төгсгөл хэсэг)

Алхам 1: “Гэр” үлгэрийн өгүүлбэр бүрийн төгсгөлийг ажиглаарай. Хүүрнэсэн эх ямар нөхцөлөөр ихэвчлэн төгссөнийг жагсааж бичээрэй.

Алхам 2: Нөхцөлүүдийг илэрхийлж буй утгаар нь ангилаарай.

Өнгөрсөн цагийн нөхцөл

Одоо цагийн нөхцөл

Ирээдүй цагийн нөхцөл

Алхам 3: Цагаар төгсгөх нөхцөлтэй дараах үйл үгийг бүтцээр задлаарай.

хийв	
өгнө	
жаргажээ	
боллоо	

Алхам 4: Цагаар төгсгөх нөхцөлийн утгыг зөв илэрхийлсэн нэг нэг өгүүлбэр зохиож бичээрэй.

Заадаг цаг	Нөхцөлийн утга	Нөхцөл	Жишээ өгүүлбэр
Өнгөрсөн цаг	Үйл явдал мэдэгдэж өнгөрсөн	-в -лаа, -лээ, -лоо, -лөө	
	Үйл явдал мэдэгдээгүй өнгөрсөн	-жээ, -чээ	
Одоо цаг		-на, -нэ, -но, -нө	
Ирээдүй цаг		-на, -нэ, -но, -нө	

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Биеэр төгсгөх нөхцөл: Үйл хөдлөлийг нэг, хоёр, гуравдугаар биеийн аль нэгээр гүйцэтгүүлэхээр хүсэх, даалгах, захирах, зөвлөх, шаардах, гуйх, шийдэх, сануулах, ерөөх зэрэг өгүүлэгчийн хандлагыг илэрхийлэх нөхцөлүүдийг хэлнэ. Найруулгад маш олон өнгө, хандлага, олон өөр утгаар хэрэглэгдэнэ.

Дасгал 21: Үйл үгийн биеэр төгсгөх нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Ажиллах эх: Гэр (үлгэрийн гол ба төгсгөл хэсэг)

Алхам 1: Үйл хөдлөлийг нэг, хоёр, гуравдугаар биеийн аль нь гүйцэтгэж байгааг үйлийн эзэн, нөхцөлийн утгаар тодорхойлоорой.

Бие	Нөхцөлийн утга	Нөхцөл	Жишээ
1	Шийдэх	-я, -е, -ё	Ашигт мал сүргээ магъя. (би)
	Даалгах	-сугай, -сүгэй	Ач буян, амжилт бүтээлээ өргөсүгэй. (би)
	Тушаан захирах	тэг нөхцөл	Нөхрөө харж биеэ зас. (чи)
2	Зөвлөх	-аарай ⁴	Өрх өргөж, сум сунгаж яваарай. (чи)
	Шаардах	-аач ⁴	Морио эмээллээд, салхи шиг давхиач.(чи)
	Хүндэтгэх	-гтун, -гтүн	Та нар тавтай морилогтун. (та)
	Сануулах	-уузай, -үүзэй	Хүсэл зорилгоосоо няцуузай. (чи)
	Зөвшөөрөх	-г	Өөрийнхөөрөө явбал яваг. (тэр)
	Ерөөх	-тугай, -түгэй	Саасан сүү нь сав дүүртүгэй. (түүний)
3	Мөрөөдөх	-аасай ⁴	Эх орон, элгэн садан минь энх байгаасай. (тэр)

Алхам 2: “Гэр” үлгэрийн гол дүр болох өвгөний захиасыг дэлгэрүүлж бичээрэй. Тэгэхдээ өгүүлбэрүүдээ биеэр төгсөх нөхцөлөөр хувилгаж, тушаах, сануулах, зөвшөөрөх, ерөөх, хүсэх зэрэг олон утгатай болгоорой.

Үлгэр ингээд дууссангүй ээ. Өвгөн аав нь нэг өдөр хэвтэрт орж, хөвгүүддээ “Төрөх нэг өдөр байхад, төгсөх нэг өдөр бий. Ханан гэрээсээ аав нь хадан гэр лүүгээ буцах боллоо” гэжээ. Яаж аж төрөхийг гэр чинь заагаад өгнө. Гагцхүү гэрийн бүслүүрээ л чангалж яваарай.

.....

” гэжээ.

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 22: Үйл үгийн тухай мэдлэг, ойлголтоо бататгаарай.

Тээрэмчин

... Би хүрээ аваад эргэтэл сая уур савсуулан хаясан хомоолны тас нясхийн хага үсрэх дуутай зэрэгцэн, чихний үзүүр часхийн хорслоо.

Хонгил шиг хүйтэн, тээрмийнхээ байшинд яаран ортол том ширмэн цөгцтэй дэнгийн гэрэл хаалганы салхинд цохигдон, унтарчих шахам сүүмэлзэв. Би эвдэрч гажсан хаалгаа чихруулан өргөж хаагаад, хананд өлгөөтэй дэнгийн бадамласан голыг заслаа. Байшингийн хана, туурга хүртэл гэрэлтэв. Би шигшүүрийнхээ элэгдэж мөлийсөн гишгүүрийн ард сууж, “Чш” гэж чимээ өгмөгц хар морь тээрмийн дүгрэг чулууг харшуулан эргүүлж, хад хайрга нь ил гартлаа ховилтон элэгдсэн эх ч үгүй, төгсгөл ч үгүй тээрэм тойрсон нарийн жимээр жигдхэн гэлдэрч эхэллээ. Хад чулуу цухуйсан хатуу хөрсийг зөөллөж, тэгшлэх санаатай асгасан шороо маань морины хөлд тарж, хар морь минь хатуу чулуунд туурайгаа салбартал элээж, бүдчин гэлдэрсээр байв..

- Тодруулсан өгүүлбэр дэх үйл үгийг тусах, эс тусах утгаар нь ялгаж бичнэ үү.
 - Тусах үйл үг
 - Эс тусах үйл үг
- Налуугаар бичсэн хэсэгт байгаа үйл үгийг үүсмэл, үүсмэл бишээр нь ангилна уу.
 - Үүсмэл үйл үг
 - Үүсмэл биш үйл үг
- Цэнхрээр бичсэн хэсэгт байгаа өгүүлбэрт хэрэглэсэн нөхцөлдүүлэн холбох нөхцөл, ямар утга үүргээр орсныг тайлбарлаарай.

Хоёр үйл зэрэгцэж байгааг:

Үйлүүд дараалж байгааг ...ард сууж, ... чулууг эргүүлж, ... гэлдэрч эхэллээ.

Цаг хугацааны утгаар

Шинж илэрхийлсэн утгаар

Шалтгааны утгаар

Үйл үргэлжилж байгааг

- Тодотгон холбох нөхцөлтэй дараах үгс нь ямар үгийн утгыг тодруулсныг бичээрэй.

Уур савсуулан хаясан, хага үсрэх, эвдэрч гажсан, дэнгийн бадамласан, элэгдэж мөлийсөн, тээрэм тойрсон, асгасан

Дууссан:онсарөдөр

5. Дээрх эхэд өгүүлбэрийн төгсгөл нь яагаад мэдэгдэж өнгөрсөн цаг буюу –в, -лаа, нөхцөлөөр төгссөний учрыг тайлбарлаарай.

- A. Хүүрнэсэн эхийн өгүүлбэрийг цагаар төгсгөх нөхцөлөөр хувилгадаг.
- B. Өгүүлэгч нь би баатар учраас
- C. Тухайн үйл явдлыг өгүүлэгч мэдээгүй учраас
- D. Үйл явдал нь одоо, ирээдүй, өнгөрсөн 3 цагт өрнөж байгаа учраас

6. Дээрх эхийн үйл явдлыг сануулсан, зөвлөсөн, шаардсан, зөвшөөрсөн, хүссэн утгатай захиасаар нэмж дэлгэрүүлээрэй.

.....

.....

.....

.....

7. Дараах үгсийг үгийн бүтцээр задлан, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

- Бадамласан
- Гэрэлтэв
- Салбартал

8. Дараах өгүүлбэрт хэдэн үйл явдал байна вэ?

... Би хүрээ аваад эргэтэл сая уур савсуулан хаясан хомоолны тас нясхийн хага үсрэх дуутай зэрэгцэн, чихний үзүүр часхийн хорслоо.

- A. 7
- B. 8
- C. 9
- D. 10

9. Дараах жинхэнэ нэр ба үйл үгийг утгаар зөв холбон найруулж, үйл явдлыг гүйцээгээрэй. **Нөхөх үг:** (талхиж, суудалдаа, нүхэнд нь, хөлөөрөө, чулуун, халих, хутгуураар, шигшүүрэндээ)

Тэгээд бул дээгүүр бялхан хивгийг модон хусаж, хийгээд тээрмийнхээ идшийг тохируулан гол савх бургас нэмж, дүүжин суунгаа гишгүүрийг хоёр ээлжлэн эхэллээ.

10. Хүүрнэсэн эхийн үндсэн шинжүүдийг нэрлээрэй. Зөв хариултуудыг тэмдэглэнэ үү.

- A. Үйл явдалтай. Үйл явдал нь тодорхой орчинд, цагийн дарааллаар учир шалтгааны уялдаатай, нэг нь нөгөөгөөсөө урган гарч өрнөдөг.
- B. Үйл явдал нь тодорхой орчинд нэг нь нөгөөгөөсөө урган гараагүй, биеэ дааж өрнөдөг.
- C. Дүрүүдтэй. Тэдний хэлсэн үг (яриагаар), хийсэн үйлдлээр үйл явдал дүрслэгддэг.
- D. Үйл явдлын бүтцээр дамжин сэдэв, санаа илэрдэг.
- E. Хүүрнэсэн эхийн үйл явдал нь жинхэнэ нэр, үйл үгийн хослолоор бүтдэг.

Дууссан:онсарөдөр

Өдрийн тэмдэглэлийн утга, бүтэц

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Өөрт тохиолдсон онцгой содон үйл явдлыг цагийн дарааллаар, өөрийн мэдрэмж, сэтгэгдэл, сэтгэл хөдлөл, үнэлгээ дүгнэлт зэргийг өнгөрсөн цагт илэрхийлэн бичсэнийг өдрийн тэмдэглэл гэнэ. Өөрт тохиолдсон явдлаа бичиж байгаа учраас “би, надад, миний” гэх мэтээр 1-р биеэс өгүүлнэ.

Дасгал 1. Өдрийн тэмдэглэлийн утга, бүтцийн онцлогийг тайлбарлаарай.

1991 оны гуравдугаар сарын 30

Сэтгэл санаа минь дундуур явах боллоо. Улс орон маань хаашаа л яваад байна даа.

Монголчуудын минь хүнлэг чанар улам муудаж, нэг нь нөгөөгийнхөө улыг шагайж, мууд дурлах болжээ.

Хийж чадаж байсан зүйлээ хүмүүс хийж чадахаа больжээ. Ажил хийж, юм бүтээе гэсэн оргилуун сэтгэл хэнд ч бараг байхгүй болох нь. Улсын маань дансууд улайснаас дэлгүүр хоршоо хоосорлоо. Улсын үйлдвэрүүд түүхий эдгүй болж, хүмүүсийн хэрэгцээт бүтээгдэхүүн нүдний гэм боллоо.

Бараа таваар ч яах вэ бий болох л биз. Харин өдрөөс өдөрт хомсодсоор байгаа хүнлэг чанарыг юугаар нөхөн сэргээнэ дээ.

Ж. Гүррагчаа

Огноо, тухайн үеийн нөхцөл байдал, сэтгэл хөдлөл

Болсон хэрэг явдлын дүрслэл түүний талаарх бичигчийн сэтгэл хөдлөл, сэтгэгдэл мэдрэмж

Хэрэг явдлын дүгнэлт, бичигчийн бодол, бичигчийн нэр

Алхам 1. Өдрийн тэмдэглэлд хэрэглэсэн үгсийн утгыг толь бичиг ашиглаж тайлбарлаарай.

- сэтгэл дундуур- ямар нэгэн юм санаанд нь хүрэхгүй байх
- ул шагайх
- данс улайх
- чанар муудах
- нүдний гэм
- мууд дурлах
- хоршоо
- таваар
- хүн чанар

Алхам 2. Учир шалтгааны асуултад хариулаарай.

а. Ж. Гүррагчаа **яагаад** сэтгэл санаа нь дундуур явах болсон бэ?

.....

б. Хүмүүс нэгнийхээ мууд дурлах болсны **шалтгаан юу вэ?**

.....

в. Дэлгүүр хоршоо **юуны улмаас** хоосорсон бэ?

.....

г. **Юунаас болж** хүмүүсийн хэрэгцээт бараа үгүй болсон бэ?

.....

Алхам 3. Өдрийн тэмдэглэлийн хэл зүйн онцлогийг жишээгээр тайлбарлаарай.

Бүтэц	Агуулга	Жишээ
Эхлэл хэсэг	1. Огноо	1.
	1. Тухайн үеийн нөхцөл байдал 2. Бичигчийн сэтгэл хөдлөл	1. Улс орны хөгжил уруудсан 2.
Гол хэсэг	1. Онцлох 2 үйл явдал 2. Үйл явдлын талаарх бичигчийн мэдрэмж сэтгэгдэл	1. а. Хүн чанар муудсан. б. 2. Хийж чадаж байсан зүйлээ хүмүүс хийж чадахаа больжээ.
Төгсгөл хэсэг	1. Хэрэг явдлын дүгнэлт, бичигчийн бодол сэтгэгдэл 2. Бичигчийн нэр	1. 2.

Алхам 4. Өдрийн тэмдэглэлийн утга, бүтцийн хамаарлыг жишээгээр тайлбарлаарай.

Хэлний хэрэглээ	Даалгаврыг хийх заавар	Жишээ
1-р биеэс бичих	“Би”-г заасан үг, бүтээвэр
Өнгөрсөн цагийн нөхцөл хэрэглэх	Өгүүлбэр бүрийг төгсгөсөн үгийг түүж бичээд, нөхцөлийг тодруулах	боллоо, болжээ,.....

Бичигчийн сэтгэлийн өнгө аяс

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр




Бичигчийн өгүүлж буй зүйлдээ хандах хандлагыг сэтгэлийн өнгө аяс гэнэ. Бичигчийн мэдрэмж, сэтгэл хөдлөл, бодол сэтгэгдлийн таатай, таагүй чигийг хандлага гэнэ. Өнгө аяс нь баймж үг, бүтээврээр илэрнэ.

Дасгал 2. Бичигчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлаарай.


Алхам 1. Бичигчийн сэтгэл хөдлөлийг эхийн жишээгээр тайлбарлаарай. Хүснэгтийг гүйцээнэ үү.

Сэтгэл санааны байдал	Нотолгоо
Сэтгэл дундуур	
Зовнисон	Улс орон маань хаашаа л яваад байна даа.
Харамссан, түгшсэн	
Найдлага тавьсан	
Санааширсан	

Алхам 2. Болсон үйл явдлыг бичигч яаж мэдрэснийг тайлбарлаарай. Холбож зурна уу.



1. Монголчуудын минь хүнлэг чанар улам муудаж, нэг нь нөгөөгийнхөө улыг шагайж, мууд дурлах болжээ. Ажил хийж, юм бүтээе гэсэн оргилуун сэтгэл хэнд ч бараг байхгүй болох нь.



2. Хийж чадаж байсан зүйлээ хүмүүс хийж чадахаа больжээ. Улсын маань дансууд улайж, дэлгүүр хоршоо хоосорлоо. Улсын үйлдвэрүүд түүхий эдгүй болж, хүмүүсийн хэрэгцээт бүтээгдэхүүн нүдний гэм боллоо.



Алхам 3. Бичигчийн сэтгэгдлийг илэрхийлсэн өгүүлбэрийг ялган бичээрэй.

1. Улс орон маань хаашаа л яваад байна даа.
2.
3.

Алхам 4. Бичигчийн сэтгэлийн өнгө аясыг дүгнээрэй.

Бичигч ньхувьд ч, харж, хүртэж зүйлийн хувьд ч, бодол хувьд ч таагүй байгаагаас бичигчийн сэтгэлийн өнгө аяс илэрч байна.

Дасгал 3. Баймж бүтээврийг ашиглан, сэтгэлийн өнгө аясаа илэрхийлж сураарай. Т3

Алхам 1. Бичигчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлаарай.

Өгүүлбэр	Өнгө аяс	Өнгө аясыг илэрхийлсэн хэлний нэгж
Өглөө ажилдаа ирэх бүрдээ их ажил хийх, юм бүтээх, цагийг үр бүтээлтэй өнгөрөөх бодолтой ирэх юм.	Баталж нотолсон	-х юм.
Орой ажлаас тарахад хийсэн юм багатай өнгөрсөн байх юм.	Чамлаж голсон	-сөн байх юм
Сайн үйл бүтээсэн сайхан хүнтэй уулзах болгондоо нэг овоо босгоод байх юм сан.		
Яргуйд хүмүүс их дуртай.		
Юунд тэглээ яргуйд дурладаг юм бол оо!		
Хөлдүү хөрсийг нэвтэлж, хамгийн түрүүнд цухуйдаг болохоор нь хайрладаг биз ээ.		

Алхам 2. Дараах өгүүлбэрийн өнгө аясыг өөрчилж бичээрэй.

- Баталсан Нүдэнд харагдах түмэн одны наян найман орд дундуур одон хөлгийн жолоо барилцаад явж байлаа.
- Таамагласан
- Бахархсан
- Хүссэн
- Дурссан

Алхам 3. Дараах баймж бүтээврийг ашиглан өгүүлбэр зохиож бичээрэй.

л, ч, даа, шүү, вий, шив, даг, бүү

.....

.....

.....

.....

Алхам 4. Баймж бүтээврийг буруу бичсэн үгийг олоод, засаж бичээрэй.

Энэ шөнө Иосиф Сталины хөшөөг буулгалаа. Хөшөөнө хэнд гэм хийснийг мэдэхгүйм. Хөшөөг нурааж халснаар Сталинаас өшөөгөө авч байна гэж бодож байгаам болвуудаа. Ингэлээ гээд түүхийг ч лав шинээр сэлбэж нөхөх бишдээ. Энэ хөшөө бол зөвхөн түүхийн дурсгалт зүйл гэдгийг ойлгомоорл санагдахым.

.....

.....

.....

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Өдрийн тэмдэглэл бичихийн ач тус:

- Тухайн үйл явдалд хандах хандлага, мэдрэмж, сэтгэл хөдлөлөө илэрхийлж сурна.
- Өөрийнхөө хувьсал өөрчлөлтийг мэдэрнэ.
- Хойч үедээ амьдралын туршлагаа өвлүүлнэ.
- Дурсамжаа сэргээнэ.

Дасгал 4. Хэлц үг ашиглан, өдрийн тэмдэглэл бичээрэй.

Алхам 1. Тохиолдсон явдлаа сонгоорой. Сонголтын өмнөх нүдэнд + тэмдэг тавиарай.

	Баяртай үйл явдал		Жаргалтай байсан үйл явдал		Уйтгар, гунигтай үйл явдал
	Сэтгэл амраасан үйл явдал		Айж түгшсэн үйл явдал		Уурлаж, бухимдуулсан үйл явдал

Алхам 2. Сонгосон үйл явдалдаа тохируулан дараах хэлц үгээс ашиглаарай.

Баяртай	Хөл газар хүрэхгүй, магнай тэнийх, аз шовойх, амны хишигтэй, нүүр дүүрэн, хөл хөнгөрөх, тэнгэрээс од шүүрэх	Жаргалтай	сэтгэл дүүрэх, элэг зүрхний угаас, хөл хөөрцөг болох, шавай ханах, нүүр баатар, сэтгэл онгойх	Уйтгартай	Сэтгэл гундуу, элэг эмтрэх, сэтгэл хоосрох, зүрх шимшрэх, гол гонсойх, толгой ганзагалах, нүд хуурайгүй, уруу царайлах
Сэтгэл амраасан	Айдгийгаа авдартаа хийх, амьсгаа авах, зоо тэнийх, чих амрах, сэтгэл амрах, цээж тэнийх, яс амрах, элэг дэвтэх	Айж түгшсэн	Сүнс зайлах, нуруугаар хүйт даах, зүрх чичрэх, зүрх алдах, алийгаа алдах, амьтан болох, толгойтой үс босох	Уурласан	Аагаа багтааж ядах, уур буцлах, цөс ихтэй, дээлэндээ багтахгүй, галзуурахад ганц хуруу дутуу, хор шар буцлах, хөмсөг зангидах

Алхам 3. Үйл явдлаа дараах бүтцийн дагуу бичээрэй.

_____	Огноо, тухайн үеийн нөхцөл байдал, сэтгэл хөдлөл
_____	Болсон хэрэг явдлын дүрслэл түүний талаарх бичигчийн сэтгэл хөдлөл, сэтгэгдэл мэдрэмж

_____	Хэрэг явдлын дүгнэлт, бичигчийн бодол, бичигчийн нэр

Дууссан:онсарөдөр

Нэгж хичээлийн үнэлгээ

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 5. Өдрийн тэмдэглэлийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Дүрсгүй жаалын өдрийн тэмдэглэл

Пүрэв гараг

Яг үнэндээ зуны амралт дуусаж, өглөө болгон эрт босож сургуульдаа явах шаардлагатай болсон гэдэгтэй эвлэрэх надад маш хэцүү байлаа. Миний том ах Родрикоос болоод зуны амралт маань анхнаасаа л тийм ч сайхан эхлээгүй л дээ.

Зуны амралт эхлээд удаагүй байтал Родрик намайг шөнө дунд сэрээгээд, “Чи зунжингаа унтаад яг хичээлийн эхний өдөр л арай гэж амжиж сэрлээ шүү” гээд ороод ирэв. “Ийм хөгийн тоглоомд хууртдаг ямар тэнэг хэрэг вэ?” гэж чи бодож болох л доо. Гэхдээ энэ бүхэн үнэхээр үнэмшилтэй байлаа. Родрик намайг хуурахын тулд өөрөө суруулийн дүрэмт хувцсаа өмсчихсөн, миний цагны сэрүүлгийг хүртэл тохируулчихсан, бас дээрээс нь шөнө дунд гэдгийг мэдэгдүүлэхгүйн тулд өрөөний маань хөшгийг хүртэл хаачихсан байлаа. Би Родрикт хууртаж сэрээд, яг л ердийн хичээлийн өдрүүдийн өглөө шиг босож хувцаслаад, өөртөө өглөөний цай бэлтгэхээр доод давхар луугаа буув.

Бодвол би дэндүү их чимээ гаргасан бололтой. Аав гэнэт бууж ирээд, “Шөнийн 3 цагт хэн овьёос иддэг байна аа” гээд л над руу хашхирч гарав. Би гайхаж, гайхаж сая л нэг юм юу болсныг ойлгох сөхөөтэй боллоо. Ингээд би хууртагдсан болохоор уйлж, Родрикийг зэмлэх нь шударга болохыг хэллээ.

Аав Родрикт үзүүлж өгөхөөр зоорь руу буухад нь би ч бас дагалдав. Би Родрикийг шангаа хүртэхийг харахыг тэсэж ядан хүлээж байсан боловч тэр муу өөрийнхөө хийсэн үйлдлийн ул мөрийг маш сайн баллаж чадсан байв.

Тэр өдрөөс хойш аав намайг нэг “шарик дутуу” нөхөр гэж бодсон гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

Грег Хефбли

1. Асуултад хариулаарай.

1. Хүүгийн зуны амралт нь анхнаасаа яагаад сайхан өнгөрөөгүй вэ?

.....

2. Ямар учраас Родрик дүрэмт хувцсаа өмсчихсөн, цагны сэрүүлгийг нь тохируулчихсан байсан бэ?

.....

3. Аав нь юунаас болж түүнд уурлаж хашхирсан бэ?

.....

4. Хүү юуны учир “Родрикийг зэмлэх нь шударга гэж үзсэн бэ?”

.....

5. Аав нь юунаас болж Родрикт “шан” хүртээгээгүй вэ?

.....

6. “шарик дутуу” нөхөр гэж аав нь бодсон гэдэгт яагаад эргэлзэхгүй байгаа вэ?

.....

2. **Өдрийн тэмдэглэлийн бүтцийн хэсэг тус бүрийн утгыг тайлбарлаарай. Харгалзуулна уу.**

1. Эхлэл хэсэг	а. Болсон хэрэг явдлын дүрслэл түүний талаарх бичигчийн сэтгэл хөдлөл, сэтгэгдэл мэдрэмж
2. Гол хэсэг	б. Бичсэн хугацаа, бичигчийн сэтгэл хөдлөл, нөхцөл байдал
3. Төгсгөл хэсэг	в. Хэрэг явдлын дүгнэлт, бичигчийн бодол, бичигчийн нэр

3. **Өдрийн тэмдэглэлийг аль биеэс бичсэнийг 2 жишээгээр батлан харуулаарай**

- A. Нэгдүгээр биеэс
- B. Хоёрдугаар биеэс
- C. Гуравдугаар биеэс

4. **Өдрийн тэмдэглэлийн өгүүлбэрийг ямар нөхцөлөөр ихэвчлэн төгсгөж бичсэн байна вэ? Хариултаа батлахын тулд хоёр жишээ бичээрэй.**

- A. Нөхцөлдүүлэн холбох нөхцөл
- B. Биеэр төгсгөх нөхцөл
- C. Цагаар төгсгөх нөхцөл
- D. Тодотгон холбох нөхцөл

5. **Тодруулсан үг, бүтээврүүдийн утгаар, бичигчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлаарай. Зөв харгалзуулна уу.**

Өгүүлбэр

1. **Яг үнэндээ** зуны амралт дуусаж, өглөө болгон эрт босож сургуульдаа явах шаардлагатай болсон гэдэгтэй эвлэрэх надад **маш хэцүү** байлаа.
2. Миний том ах Родрикоос болоод зуны амралт маань анхнаасаа **л тийм ч сайхан** эхлээгүй **л дээ**
3. Гэхдээ энэ бүхэн **үнэхээр** үнэмшилтэй байлаа.
4. **Бодвол** би **дэндүү их** чимээ гаргасан **бололтой**.
5. Би гайхаж, гайхаж сая **л нэг юм** юу болсныг ойлгох сөхөөтэй боллоо.
6. Би Родрикийг шангаа хүртэхийг харахыг тэсэж ядан хүлээж байсан боловч **тэр муу** өөрийнхөө хийсэн үйлдлийн ул мөрийг **маш сайн** баллаж чадсан байв.

Өнгө аяс

- A. Дургүйлхсэн
- B. Үнэн гэдэгт итгэлтэй байгаа
- B. Сэтгэл дундуур байгаа
- Г. Эргэлзээгээ тайлсан
- Д. Таамагласан
- Е. Таагүй, дургүй байгаа

Дууссан:онсарөдөр

Захидлын утга, бүтэц

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Хүмүүсийн энгийн харилцааны зорилгоор өөр хоорондоо илгээх бичгийг **захидал** гэнэ.

Бичигчийн санаа гэдэг нь тухайн үйл явдалд хэрхэн хандаж байгааг хэлнэ. Юуг онцолж байгаа нь чухал юм.

Дасгал 6. Захидлын утга, бүтцийг мэдэж аваарай.

Алхам 1. Захидлын утгыг тайлбарлаарай. Цэгийн оронд нөхөж бичнэ үү.

Сайн байна уу? Аав аа!

Таны шинэ ном гарч буйд бид бүхэн баяртай байна. Та ч биднээс илүү баярлаж байгаа байх.

Таны бие ямархуу байна? Аав минь, одоо л биеэ бодохгүй бол болохгүй шүү! Та ажил төрөл гээд биеэ зөнд нь орхиод байдаг талтайгаа ойлгоорой. Аль болохоор тайван байхыг бод. Эм тариа чинь олдож байна уу? Олдохгүй зүйлээ бидэнд утсаар хэлчихгүй юу?

Би шалгалтаа амжилттай өгч, оройн сургуульд орсон. Өглөө ажилдаа яваад, орой 17-21 цаг хүртэл хичээлээ хийж байна. Хичээл нь ч яах вэ, одоохондоо гайгүй л юм байна.

Ээж амарч эхэлсэн. Ганхөлөг амраад, маргаашаас хичээлдээ орно. Бусад нь ажил сургуульдаа явж байгаа. Батаа, Нараа хоёр хагас бүтэн сайнаар манайд ирдэг. Тэгэхдээ таныг дандаа асуудаг. Өвөө хэзээ ирэх вэ? гээд л шалгааж гарна даа. Одоо ч таны ирэх хугацаа дөхөж байгаа биз дээ?

Бид таны сая гаргасан шинэ номоос 10 ширхгийг авсан. Тавыг нь танд явууллаа. Ямар ч номыг хэвлэлээс гарсны дараа уншихад улам ч гоё болчихсон юм шиг санагддаг юм. Охин чинь хэзээ номоо унших юм бол доо.

За баяртай. Биеэ л сайн бодож, хямгадаж яваарай, аав аа!

Гүнээ хүндэтгэсэн охин Дэлгэрмаа
1988 оны 11-р сарын 9-нд бичив.

Бичигчийн сэтгэл хөдлөлийг харуулсан хэсэг


Захиагаа төгсгөснөө илэрхийлсэн хэсэг

Алхам 2. Эхийн бүтцийн хэсэгт тус бүрд захидлын аль цогцолбор хамаарах вэ? Холбож зураарай.

Эхлэл хэсэг

Гол хэсэг

Төгсгөл хэсэг



Амар мэндийг асуусан хэсэг

Бичигчийн сэтгэл хөдлөлийг харуулсан хэсэг

Сонин сайхан, болж байгаа хэрэг явдлыг харуулсан хэсэг

Захиагаа төгсгөснөө илэрхийлсэн хэсэг

Захидал бичигчийн санаа

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Бичигчийн санаа: Бичигч өгүүлж буй зүйлээрээ дамжуулан сануулах, ойлгуулах, ухааруулах, хөгжөөх, ятгах зэрэг тодорхой зорилгоор уншигч этгээдэд хандан өгүүлсэн чухал санааг хэлнэ. Бичигчийн санаа нь баймж нэгжээр илэрнэ.

Дасгал &. Захидал бичигчийн санааг тайлбарлаарай.

Алхам 1. Захидлыг ямар, ямар зорилгоор бичсэн байж болох вэ? Онолын ойлголт дээр тулгуурлан тайлбарлаарай.

- Ямар нэгэн зүйлийн талаар мэдээлэл өгөхийг танин мэдүүлэх зорилго гэнэ.
- Уншигчийн бодлыг өөрчлөхийг ятган итгүүлэх зорилго гэнэ.
- Уншигчийг татаж, баясгах, сэтгэлийг хөдөлгөхийг цэнгээн хөгжөөх зорилго гэнэ.

- A. Танин мэдүүлэх
- B. Ятган итгүүлэх
- C. Цэнгээн хөгжөөх

Алхам 2. Тухайн зорилгоор бичсэнийг батлах ямар ямар чухал хэсэг байна вэ? Жишээгээр баталж бичээрэй.

Таны тодорхойлсон зорилго	Батлах чухал хэсэг	Тайлбар

Алхам 3. Чухал хэсгийн утгаар бичигчийн санааг тайлбарлаарай.

Чухал хэсэг:

Бичигчийн санаа:

Чухал хэсэг:

Бичигчийн санаа:

Чухал хэсэг:

Бичигчийн санаа:

Алхам 4. Бичигч санаагаа илэрхийлэхдээ ашигласан хэлний хэрэглүүрийг тодорхойлоорой.

Өгүүлбэр: **Аав минь, одоо л биеэ бодохгүй бол болохгүй шүү!**

Өнгө аяс: **Аавдаа хандаж, анхааруулж, сануулсан**

Хэрэглүүр: **-гүй бол болохгүй шүү**

Өгүүлбэр: Та ажил төрөл гээд биеэ зөнд нь орхиод байдаг талтайгаа ойлгоорой.

Өнгө аяс:

Хэрэглүүр:

Өгүүлбэр: Аль болохоор тайван байхыг бод.

Өнгө аяс:

Хэрэглүүр:

Өгүүлбэр: Биеэ л сайн бодож, хямгадаж яваарай, аав аа!

Өнгө аяс:

Хэрэглүүр:

Алхам 5: Бичигчийн санааны тухай ойлголтоо нэгтгэн дүгнээрэй.

Бичигч нь аавдаа бичсэн захидалдаа чухалчлан хэлсэн бөгөөд энэ санаагаа хэлний нөхцөл, баймж үг, бүтээврийг ашиглан санаагаа илэрхийлжээ.

Дууссан:онсарөдөр

Захидал бичих

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 8. Захидал бичээрэй.

Анги

Хэнд

Даалгавар: Нөхөрсөг захидал бичээрэй.



Заавар: Өөрийнхөө анхны аяллын тухай тэдэнд сонирхуулж, аяллаас ойлгож ухаарсан зүйлээ бичээрэй.

Амар мэнд _____

Бичигчийн захидал бичих шалтгаан, сэтгэл хөдлөл, тухайн үеийн нөхцөл байдал

Аяллын тухай үйл явдал _____

Захидлын төгсгөл _____

Нэгж хичээлийн үнэлгээ

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 9. Захидлын утга, бүтцийг тодорхойлоорой.

Эрхэм дүү Сүрэнжавын амрыг эрье! Бид сайн явж ирлээ.

Ээж нь хүүхдэдээ, эгч нь дүүдээ бичихийн адил энгийн бөгөөд шулуун үг надаас гарахаас биш хан тэнгэрийн оргилд эс гаргаж, хаан титэм үл өмсгөнөм, чамд. Алт сувд агуурс тэргүүтнийг хэчнээн хураавч ертөнцийн ариун баялгийг ер нэгэн авч чадахгүй учир шунах сэтгэл хэзээ ч үл ханадаг. Түүн лүгээ жишихэд хэн нэгэн хэчнээн авьяастай ч орчлонгийн түг түмэн хүний хүслийг ганцаараа хэзээ ч үл хангах. Зоригоор хэдий их аашлах тусам замаас гажихын цондон болох. Сайн хүнээ сэтгэл дотроо сансрын өндөрт хүртэл магтавч нүүрэн дээр нь зөвхөн дээвэр хүртэл магтан сайшаадаг нь нисчих вэ гэж айсных байдаг.

Энэ мэт юм бодон амрахаа мэддэггүй шуугиант Европын гудамжийг харж, гайхаж сууна. Нар салхинд хэзээ ч ганддаггүй нутаг юугаа бодон, сэтгэлээ явуулан бэлчээнэм.

Баяртай! 4 сарын 16-нд очно.

С.Удвал, 1980.04.09

1. Захидлын бүтцийн хэсэгт аль үйл явдал хамаарах вэ? Цэгийн оронд нөхөж бичээрэй.

Эхийн агуулгын бүтэц	Утга, үйл явдал
1. Эхлэл хэсэг	А.
2. Гол хэсэг	Б.
3. Төгсгөл хэсэг	В.

2. Чухал хэсгийн утгаар бичигчийн санааг тайлбарлаарай. Гүйцээж бичнэ үү.

Чухал хэсэг: Алт сувд агуурс тэргүүтнийг хэчнээн хураавч ертөнцийн ариун баялгийг ер нэгэн авч чадахгүй учир шунах сэтгэл хэзээ ч үл ханадаг. Түүн лүгээ жишихэд хэн нэгэн хэчнээн авьяастай ч орчлонгийн түг түмэн хүний хүслийг ганцаараа хэзээ ч үл хангах. Зоригоор хэдий их аашлах тусам замаас гажихын цондон болох.

Бичигчийн санаа:

.....

.....

.....

Чухал хэсэг:

.....

.....

.....

Бичигчийн санаа: Талархаж, баярлаж явдаг хүнээ сэтгэл зүрхнийхээ угаас хайрла.

Ил хэлсэн сайшаал магтаал заримдаа тэр хүнд алдах нөхцөлийг бүрдүүлдэг.

3. Захидлыг ямар зорилгоор бичсэн бэ? Зөв хариултыг сонгоно уу.

- A. Мэдээлэл өгөх
- B. Ятган итгүүлэх
- C. Хөгжин цэнгэх

4. Бичигч санаагаа илэрхийлэхдээ хэрэглэсэн дараах холбох үг, бүтээврийг ажиглаад, зөв дүгнэлтийг олоорой.

Ээж нь хүүдээ, эгч нь дүүдээ бичихийн адил энгийн бөгөөд шулуун үг надаас гарахаас биш	-х+аас биш	Хан тэнгэрийн оргилд эс гаргаж, хаан титэм үл өмсгөнөм, чамд
Шунах сэтгэл үл ханах	түүн лүгээ	Түг түмэн хүний хүслийг нэг хүн хэзээ ч үл хангах
Зоригоор хэдий их аашлах	тусам	Замаас гажихын цондон
Сайн хүнээ сэтгэл дотроо сансрын уудам хүртэл магтавч	-вч	Нүүрэн дээр нь зөвхөн дээвэр хүртэл магтан сайшаадаг нь нисчих вэ гэж айсных байдаг.

- A. Адилтаж эсрэгцүүлсэн утга бүхий холбох хэрэглүүрийг ашигласан нь захидал уншигч хүний омголон бардам занг дарах, алдах вий гэж болгоомжилж, сургамжилсан бичигчийн санаа юм.
- B. Адилтаж эсрэгцүүлсэн утга бүхий холбох хэрэглүүрийг ашигласан нь захидал уншигч хүний сайн сайхан авьяас чадварыг тэнгэрт тултал магтан дуулж, “би чиний дэргэд өчүүхэн” хэмээн өөрийгөө голж чамласан санаагаа гаргажээ.

5. Сурагчийн бичсэн захидлыг бүтцийн дагуу дарааллаар нь байрлуулаарай. Зөв харгалзуулна уу.

1.Амар мэндийг асуусан хэсэг

2.Бичигчийн захидал бичих үеийн сэтгэл хөдлөлийг харуулсан хэсэг

3.Болж өнгөрсөн хэрэг явдлыг харуулсан хэсэг

4.Захиагаа төгсгөснөө илэрхийлсэн хэсэг

А.Диваажинд яваа тандаа сайн сайхныг хүсье. Хүндэтгэсэн, Охин чинь, 2020.05.10

Б. Тандаа захидал бичилгүй уджээ. Хязгааргүй холын аянд гарсныг тань мэдэж байгаа ч таныг санан захидал бичин сууна

В.Сайн байна уу? Өвөө!

Г. Хязгааргүй холын аянд гарснаас хойш хэдэн сарын дараа та минь охиныхоо зүүдэнд “ Би сайн байгаа. Санаа бүү зовоорой.” гээд над руу харан инээмсэглэж үзэгдсэн. Зүүдэндээ баяр гунигийн нулимс дуслуулан байж таныгаа үдсэн сэн. Энэ л зүүд надад жаргал нэмсэн шүү. Таныг холын аянд мордохоос өмнө би жинхэнэ утгаараа жаргаж байжээ. Танд минь энэ хорвоогийн бүх юм байж. Зун болгон тань дээрээ очин эрхэлж эрхэлж, намар нь буцаад л ... Зун цагийн нахиалж буй мод, цэцэгс оюу ногоон өнгөөр солонгорсоор очих замыг минь тантай хамт тосдог байлаа. Намар намрын алтарсан замаар гэр лүүгээ буцахад минь та л үддэг байлаа. Ийнхүү солонгорсон, алтарсан замаар өнө мөнхөд нааш, цааш зорчих юм шиг, үргэлж угтуулж, үдүүлж байх юм шиг санасаар... Гэтэл нэг л зун. Нахиалж буй моддыг харж амжилгүй өвөөгөө диваажингийн замд үдсэн сэн. Ингээд л ногоорон тосож, алтран үддэг зам маань дэндүү энгийн болсон шүү, өвөө минь!

Дууссан:онсаредөр

Мэдээ мэдээллийн утга, бүтэц

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Мэдээ: Мэдээ гэдэг нь тухайн улс орон эсвэл дэлхийд эсвэл үйл ажиллагааны тодорхой хүрээнд болж буй сүүлийн үеийн үйл явдлуудын талаар сонин хэвлэлд цацагдаж, радио, телевизээр цацагддаг мэдээллийн хэлбэрийг хэлнэ. Уншигч, сонсогч, үзэгчдэд хэзээ? хаана? хэн? юуг? яагаад? яав? гэсэн 6 асуултад болсон үйл явдлын тухай хариулт өгдөг бөгөөд энэ нь мэдээний үндсэн шинж юм.

Мэдээлэл: Мэдээлэл бол таны олж авсан мэдлэг, олж мэдсэн баримтууд юм.

Дасгал 10. Мэдээний үндсэн шинжийг ойлгоорой.



Москва. 1981 оны гуравдугаар сарын 22.

Зөвлөлт Холбоот улсад өнөөдөр Москвагийн цагаар 17 цаг 59 минутад сансрын “Союз-39” хөлөг хөөргөв. Хөлгийн дарга ЗХУ-ын баатар, сансрын нисэгч Владимир Жанибеков, шинжлэн судлагч, сансрын нисэгч БНМАУ-ын иргэн Жүгдэрдэмидийн Гүррагчаа нарын бүрэлдэхүүнтэй олон улсын баг сансрын хөлгийг жолоодож байна.

Ардын эрх, 1981.03.22, дугаар 70

Алхам 1. Дээрх мэдээний сэдвийг тодорхойлоорой.

.....

Алхам 2. Дараах асуултад хариулж, мэдээний утгыг ойлгоорой

Үйл явдал хаана болсон бэ?

.....

Үйл явдал хэзээ болсон бэ?

.....

Үйл явдалд хэн оролцсон бэ?

.....

Юуг жолоодсон бэ?

.....

Алхам 3. Дээрх 4 асуултын дагуу товч мэдээ болгон хурааж бичээрэй

.....

Мэдээг дэлгэрэнгүй, хураангуй гэж 2 ангилна.

Алхам 4. Дараах мэдээг 6 асуултад хариулж бичээрэй.

1970-аад оноос говийн бүсийн хүмүүс төв суурин газрын түлшний хэрэгцээнд заг модыг их хэмжээгээр хавтгайруулан бэлтгэдэг болсноос 125 мянган га газрын заг бүрэн устсан. Одоо 370 гаруй мянган га газрын заг байгалийн аясаар ургах чадвараа алджээ. Мөн автомашинууд олон салаа зам гаргаж, газрыг уул уурхайн зориулалтаар ухаж сэндийчиж, тариалангийн талбайг элэгдэл эвдрэлд оруулах зэргээр хүний буруутай үйл ажиллагаанаас цөлжилт эрчимжиж байна.

Асуулт	1-р өгүүлбэр	2-р өгүүлбэр	3-р өгүүлбэр
Хэзээ?	1970-аад оноос		
Хаана?	говийн бүсийн		
Хэн? Юу?	хүмүүс		
Хэнийг?Юуг?	заг модыг		
Яагаад?	түлшний хэрэгцээнд бэлтгэдэг болсноос		
Яав?	125 мянган га газрын заг бүрэн устжээ.		

Алхам 5. Мэдээг найруулж дэвтэртээ бичээрэй.

Асуулт	Үйл явдал
Хэн?	“Хандлагаа өөрчилъе” аяныг санаачлагчид
Хаана?	Богд хан ууланд
Хэзээ?	2021 оны 5 сарын 26-нд
Юуг	мод тарих 2 өдрийн арга хэмжээний нээлтээ
Яагаад?	2 га газарт 2200 мод тарьж, ойжуулахаар
Яав?	хийлээ.

.....

.....

.....

.....

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 11. Мэдээллийн гол утгыг загварчилж харуулаарай.

Агаарын бохирдол

Агаарын бүтэц шинж чанар өөрчлөгдөхийг агаарын бохирдол гэдэг бөгөөд энэ хүний эрүүл мэнд, экосистемд таагүй нөлөө үзүүлдэг. Агаарын бохирдолтыг байгалийн ба хүний гаралтай гэж ангилж болно.

Байгалийн гаралтай агаарын бохирдол нь байгалийн үйл явцаар үүсэх бөгөөд үүнд галт уул дэлбэрэх, уулын чулуулаг элэгдэх, ургамал хэт их цэцэглэх, /хөл газрын ургамал- энгийн яриагаар хогийн ургамал гэж нэрлэдэг шарилж, лууль / ойн болон гал түймрийн утаа гэх мэт хамаарна.

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын бохирдол нь үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад янз бүрийн хорт бодис агаарт хаягдсанаас үүсдэг. Энэ нь байгалийн гаралтай агаарын бохирдлыг цар хүрээгээрээ давдаг. Хүний үйл ажиллагаанаас гаралтай агаар бохирдуулах эх үүсвэрүүд гэвэл, сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж байгаа хүн амын механик хөдөлгөөн ихэссэн, гэр хороолол тэлж, хотын нягтрал нэмэгдсэн явдал юм. Мөн хот дотор шинээр баригдаж байгаа байшин барилгын хоорондын зай багасаж, агаарын урсгалыг сааруулж, бохирдлын сарнилтыг саатуулж байна.

Агаарын бохирдлыг хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр нь хурц ба архаг гэж 2 ангилдаг. Хурц нөлөөлөл гэдэг нь агаар бохирдуулж байгаа хорт бодисын хольцууд нь /концентрацаар/ өндөр идэвхээр богино хугацаанд хүн, амьтан, ургамлын амьдрах үйл ажиллагаанд хорт нөлөө үзүүлэхийг хэлнэ.

Архаг нөлөөлөл гэдэг нь агаар мандалд байгаа хорт бодисууд бага идэвхээр удаан хугацааны турш хүн, амьтан, ургамлын амьдрах үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхийг хэлнэ.

Хүний хамгийн үнэт эрдэнэ бол эрүүл мэнд юм. Хүн амьтны эрүүл явах үндэс нь цэвэр агаараар амьсгалах. Хүн хүчилтөрөгчгүйгээр хэдэн хоромч байж чадахгүй. Иймээс хүний гаралтай хүчин зүйлийн нөлөөллийг багасгах нь бидний ирээдүйн амьдралд оруулж буй үнэт хувь нэмэр байх болно.

<http://catd.mn/post/5489>


Алхам 1. Дээрх мэдээллийн сэдвийг тодорхойлоорой.

Алхам 2. Дээрх мэдээллийн гол санааг тодорхойлоорой. Зөвийг дугуйлаарай.


- A. Хүний хамгийн үнэт эрдэнэ бол эрүүл мэнд юм.
- B. Хүн амьтны эрүүл явах үндэс нь цэвэр агаараар амьсгалах.
- C. Хүн хүчилтөрөгчгүйгээр хэдэн хоромч байж чадахгүй.
- D. Хүний гаралтай хүчин зүйлийн нөлөөллийг багасгах нь бидний ирээдүйн амьдралд оруулж буй үнэт хувь нэмэр байх болно.

Алхам 3. Мэдээллийн баримтыг шинжилж, загварчлаарай.


1, 2-р цогцолборыг загварчилбал:



3-р цогцолбор буюу цэнхрээр тодруулсан хэсгийн загварыг гүйцээгээрэй.



4-р цогцолбор буюу ягаанаар тодруулсан хэсгийн утгыг загварчилж, зураарай.



Мэдээ, мэдээлэл бичих

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 12. Мэдээ бичээрэй.



Алхам 1. Мэдээний зорилгыг тодорхойлоорой. Зөвийг дугуйлаад, тайлбар бичнэ үү.

- A. Мэдээлэл өгөх
.....
- B. Цэнгээн хөгжөөх
.....
- C. Ятган итгүүлэх
.....

Алхам 2. Сургууль дээрээ ойрын үед болсон үйл явдлыг 6 асуултын дагуу мэдээлж бичээрэй.

Асуулт	Мэдээгээ төлөвлөх хэсэг
Хэзээ?	
Хаана?	
Хэн?	
Юуг?	
Яагаад?	
Яав?	

Мэдээгээ найруулж бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

Дууссан:онсарөдөр

Намтрын утга, бүтэц


Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Намтар гэдэг нь хүний төрсөн цагаас хойших амьдралын бүхий л түүхийг хэлнэ. Намтар нь товч, дэлгэрэнгүй 2 янз байна. Намтрыг он цагийн дарааллаар бичдэг.

Дасгал 14. Намтрын утга, бүтцийг тайлбарлаарай.

Галилейн намтар



Галилео Галилей 1564 онд Италийн Писад дээд зиндааны боловч ядуу, тоо хөгжим сонирхдог эцгийн гэр бүлд мэндэлжээ.

1581 оны нэгэн өглөө сүмд хүмүүс өвдөг сөхрөн мөргөл хийж байхад Галилей таазанд өлгөөтэй дэн савлахыг ажиглан ижил хугацаанд урагш хойш хөдөлж, дэнгийн хурд болон савлах зай нь багассаар байсныг анзаарчээ. 17 настай байсан тэрээр ажиглалтаасаа үүдэн туршилт хийсэн байна. Олсны үзүүрт ачаа зүүж, энгийн нэг дүүжин хийгээд олс ижил урттай байхад ачаа адил хугацаанд савладгийг тогтоож, олс урт байхад ачаа хол, богино байхад ойрхон савладаг гэдгийг олж мэджээ.



1609 -1610 онд гурав дахин өсгөдөг одон орны дуран авай бүтээж, сарны гадаргуу өө сэвгүй биш барзгар төдийгүй сар бөөрөнхий гэдгийг баталжээ.

Галилей 1637 онд хараагүй болсон ч 1642 оны 1-р сарын 8-нд нас барах хүртлээ ажилласаар байсан гэдэг.

Алхам 1. Дараах асуултад хариулж, намтрын утгыг ойлгоорой.

1. Хэний тухай намтар вэ?
2. Түүний эцгийн нэр хэн бэ?
3. Тэр хэдэн онд төрсөн бэ?
4. Тэр хаана төрсөн бэ?
5. Их эрдэмтэн болохын эхлэл түүх нь юу байв?
.....
.....
6. Тэр дараа нь хэзээ, юуг бүтээсэн бэ?
.....
.....
7. Тэр хэдэн онд нас барсан бэ?

Алхам 2. Дээрх намтарт өгүүлсэн түүхүүд нь бүтцийн аль хэсэгт хамаарах вэ? Зөв байрлуулж бичээрэй.

1. Галилей мэндэлжээ.


2. Галилей савлаж буй гэрлийг анзаарч, туршиж, мэдсэн.

3. Галилей дуран бүтээж, сарны шинжийг баталжээ.

4. Галилей хараагүй болсон хийгээд, нас барсан.

Эхлэл хэсэг	
Гол хэсэг	
Төгсгөл хэсэг	

Алхам 4. Намтраас гол мэдээлэл, дэлгэрүүлсэн мэдээллийг ялгаж бичээрэй.



Дасгал 15. Намтрын хэл зүйн онцлогийг тайлбарлаарай.

Алхам 1. Дээрх намтрын өгүүлбэр бүрийг төгсгөсөн үйл үгийг түүж бичээд, нөхцөлийг тодруулж будаарай.

мэндэлжээ,

Алхам 2. Үйл явдлын дарааллыг хэлний ямар хэрэглүүрээр илэрхийлсэн байна вэ? Жишээ олж бичээрэй.

- Тооны нэрээр 1564 онд,
- Цагийн нэрээр
- Цагийн утгатай өгүүлбэрээр

Алхам 3. Дээрх намтар нь хүүрнэмж хэв маягаар бичигдсэн болохыг 2 жишээгээр батлаарай.

Хүүрнэмж эхийн үндсэн шинж	Батлах жишээ
Үйл явдал нь цагийн дарааллаар өрнөдөг.	1. 2.
Өгүүлбэрүүд нь цагаар төгсгөх нөхцөлөөр хувилдаг.	1. 2.

Дууссан:онсарөдөр

Намтар бичих

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 16. Намтар бичээрэй.

Алхам 1. Бичих төлөвлөгөө гаргаарай. Нөхөж бичээрэй.

Үндсэн мэдээлэл

Нэр

Овог

Төрсөн он сар өдөр
.....

Төрсөн газар

Үндэс угсаа

Төрсөн үеийн баримт, түүх

.....
.....
.....
.....
.....

Хамгийн чухал үйл явдал

.....
.....
.....
.....
.....

Ажиллах, сурахад урам өгсөн үйл явдал

.....
.....
.....
.....
.....

Хамгийн сэтгэлд үлдсэн үйл явдал

.....
.....
.....
.....
.....

Одоогийн ажил байдал

.....
.....
.....
.....
.....

Алхам 2. Намтрын бүтэц, он цагийн дарааллын дагуу материалуудаа байрлуулж, дэвтэртээ намтар бичээрэй.

Дууссан: он сар өдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 17. Дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

1. Өгүүлбэрүүдийг уншаад, он цагийн дарааллаар байрлуулж, товч намтар бүтээгээрэй.

1. 1172 онд Жамухатай анд бололцжээ.

2. 1206 онд Их Монгол Улсыг байгуулав.

3. 1177 онд Боорчитой анд бололцов.

4. 1170 онд Тэмүжиний аав Есүхэй баатар Татаруудад хорлогдов.

5. 1171 онд Тайчууд аймаг тэднээс салж нүүв.

6. 1189 онд Хамаг Монголын хаанд өргөмжлөгдсөн.

7. 1162 онд Тэмүүжин мэндлэв.

8. 1178 онд Бөртэтэй гал голомтоо бадраав.

Дараалуулсан нь:

2. Дараах баримтаар, дээрх товч намтраас тохирохыг сонгон дэлгэрүүлнэ үү. Зөв харгалзуулаарай.

а. Ононы Дэлүүн болдогт Есүхэйн ууган хүү болон мэндэлжээ.

б. Есүхэй Тэмүжинийг 9 настай байхад нь ургийн газар хүргэж өгөөд буцах замдаа Цэгцэрийн шар талд Татаруудад хорлогдов.

в. Есүхэй баатарыг насан өөд болсны дараа Тайчууд аймаг Өэлүнийг хүүхдүүдийн хамт нутаг нь орхиж нүүв.

г. Найман шарга морио алдах үед сураг хэлж, зам зааж, тэднийг олж авахад тусалсан тул анд бололцжээ.

д. Алтан, Хучар, Сача бэхи нар бүгдээр зетэлцэж, хаан болгов.

Харгалзуулсан нь:

3. Намтрын зорилго юу вэ?

А. Танин мэдүүлэх

В. Хөгжөөн цэнгээх

С. Ятган итгүүлэх

4. Намтарт үйл явдлыг ямар дарааллаар харуулсан байна вэ?

А. Тооны нэрээр 1564 онд,

В. Цагийн нэрээр

С. Цагийн утгатай өгүүлбэрээр

Д. Орны дарааллаар

Дууссан:онсарөдөр

Орон цагийн нэрийн утга, хэл зүйн онцлог

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Хүн, юм, үзэгдлийн орших орон, зүг чиг, цаг хугацааг нэрлэн заасан хаана, хаанаас, хаашаа, хаагуур, хэзээ гэсэн асуултад хариулагдах үгсийг **орон цагийн нэр** гэнэ. Орон цагийн нэрийг орны нэр (энд тэнд, урдаас хойноос, урагш, наагуур), цагийн (өчигдөр, одоо, маргааш, хожим) нэр гэж хоёр ангилна.

Дасгал 18. Орон цагийн нэрийн утга, бүтцийг ойлгоорой.

Алхам 1. Эхийг уншаад, хаана? хаанаас? хаагуур? хэзээ? гэсэн асуултад хариулагдах үгсийг тодруулж будаарай.

Дээрээс нар гарч, **доороос** элс төөнөсөн их говийн аагим халуунд ангаж ядарсан бяцхан хүү Болд хэдэн тэмээнийхээ хойноос мацна. Гэнэт элсэн манхны цаана хүн хашхирахыг сонсмогцоо босон харвал хэн ч үзэгдсэнгүй. Удалгүй манхны баруун урдуур хэдэн адуу туусан хоёр хүн гарч ирэхэд айж ганцаардсан хүүгийн нүдэнд баярын нулимс бүрхэв...

Алхам 2. Тодруулсан үгсээ ангилж бичээрэй.

- Орон байр заасан утгатай
- Зүг чиг заасан утгатай
- Цаг хугацаа заасан утгатай

Алхам 3. Жишээ үг 4, 4-ийг олж бичээрэй.

Утга	Ангилал	Жишээ үг
Орон	Орших орон заасан	хажууд,
	Зүг чиг заасан	зүүн,
Цаг хугацаа	Өнгөрсөн цаг заасан	өчигдөр,
	Одоо цаг заасан	өнөөдөр,
	Ирээдүй цаг заасан	маргааш,
	Ерөнхий цаг заасан	заримдаа,

Дууссан:онсарөдөр

Орон цагийн нэрийн хэл зүйн онцлог, найруулгын үүрэг

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Орон цагийн нэр нь жинхэнэ нэрийн тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр дутмаг хувилах ба орны нэр голдуу гарахын тийн ялгал (-аас⁴)-ын нөхцөлөөр, цагийн нэр нь голдуу гарах (-аас⁴), харьяалахын тийн ялгал (-ын, -ийн) нөхцөлөөр хувилна.

Дасгал 19. Орон цагийн нэрийн хэл зүйн онцлог, найруулгын үүргийг тайлбарлаарай.

Алхам 1. Дараах үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаарай.

Тийн ялгалын нэр	Нөхцөл	Хувилгах үг		
		саяхан	дэргэд	урьд
Харьяалах	-ын, -ийн	саяхны		
Өгөх орших	-д, -т	-		
Заах	-ыг, -ийг	саяхныг		
Гарах	-аас ⁴	саяхнаас		
Үйлдэх	-аар ⁴	саяхан		
Хамтрах	-тай ³	саяхны		
Чиглэх	-руу, -рүү	-		

Алхам 2. Орон цагийн нэрийн хувиллын онцлогийг тайлбарлаарай.

- Орон цагийн нэр бүх тийн ялгалын нөхцөлөөр хувилж байна уу? Тайлбарлаарай.

.....

- Хувилахдаа голдуу ямар ямар тийн ялгалын нөхцөлөөр хувилж байна вэ? Нэрлээрэй.

.....

Алхам 3. Дараах оньсогуудад байгаа орон цагийн нэр жинхэнэ нэрийн ямар ямар нөхцөлөөр хувилсан байна вэ? Тодруулж будаарай.

Ирээгүй дайсны өмнөөс
 Томоогүй хүүхэд явуулсан

Өглөөний хүн хонь хойшоо бэлчинэ.
 Үдшийн хонь урагшаа бэлчинэ.

Наашаа ч хэлгүй
 Цаашаа ч хэлгүй.
 Урдаас нь харвал ухна ишиг шиг
 Хойноос нь харвал хомтой тэмээ шиг

Урдаа сэрээтэй
 Дундаа хөхүүртэй
 Ардаа ташууртай.

Орон цагийн нэр бүтэх ёс

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Орон цагийн нэр нь дагаврын (хурд+ н, уд+аан) болон үг нийлэх аргаар (ойр зуур, өндөр нам, баруун хойно) бүтнэ. Дагаврын болон үг нийлэх аргаар бүтсэн үгийг үүсмэл орон цагийн нэр гэнэ. Харин язгуураараа байгаа орон цагийн нэрийг үүсмэл биш үг гэнэ.

Дасгал 20. Орон цагийн нэр бүтэх ёсыг ойлгоорой.

Алхам 1. Дараах үгсэд дагавар залгаад, утгыг нь толь бичиг ашиглан тайлбарлаарай.

Гад	-на	Утга : Орших утга
	-уур	Утга :
	-гш	Утга :
Наа	-на	Утга :
	-уур	Утга :
	-ш	Утга :


Алхам 2. Дараах нийлмэл үгсийг ажиглаад, ангилж бичээрэй

Баруун хойно, зүүн урд, эрт орой, урьд хожид, ойр орчим, түр зуур, хожим хойно, ашид мөнх, өнө эрт, алдаг оног, дээгүүр доогуур, нөгөөдрийн маргааш, уржигдар өглөө

Эсрэг, ойролцоо утгатай хоёр үг нийлж бүтсэн

Хоёр өөр утгатай үг нийлж бүтсэн

Алхам 3. Өмнөх 3 алхам дээр гүйцэтгэсэн даалгавар дээр тулгуурлаад, дараах тулгуур бичиглэлийг гүйцээгээрэй.



Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 21. Даалгаврыг гүйцэтгээрэй.

1. Эхээс орон цагийн нэрийг олоод, утгаар нь ангилж бичээрэй.

Саяхан нэг орой манай нутгийн анчин Дармаа Модотын шил дээр урьд өмнө үзэгдээгүй хоёр том амьтантай гэнэт нүүр тулгарчээ. Дармаа сандраад ямар амьтан болохыг танилгүй алджээ. Гэтэл өчигдөр ууланд жимс түүж явсан хүүхдүүд нэг бүдүүн модны дэргэд хоёр том эрээн алаг амьтан хэвтэж байхыг холоос харсан байна. Энэ лав түймрээс дайжсан хос морин шилүүс байх.

Орны нэр

Цагийн нэр

.....
.....
.....
.....

2. Дараах үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаж бичээрэй.

Тийн ялгалын нэр	Нөхцөл	Хувилгах үг		
		өчигдөр	дээр	өмнө
Харьяалах	-ын, -ийн			
Өгөх орших	-д, -т			
Заах	-ыг, -ийг			
Гарах	-аас ⁴			
Үйлдэх	-аар ⁴			
Хамтрах	-тай ³			
Чиглэх	-руу, -рүү			

3. Дараах үгсийг бүтцээр нь ангилж бичээрэй.

(Зүүн урд, доош, урдуур, ард, өнө эрт, маргааш орой, баруун хойно, гадна, арагш)

Дагаврын аргаар бүтсэн үг

Үг нийлэх аргаар бүтсэн үг

.....
.....
.....

4. Дараах хоёр эгнээ өгүүлбэрийн алинд орон цагийн нэр үндсэн утгаараа хэрэглэгдсэн байна вэ?

А. Тоглоом тоотой нь дээр
Толгой мөлжүүртэй нь дээр

В. Цаасан дээр нэртэй
Цасан дээр мөртэй

Б. Дахан доор эр
Даахин доор хүлэг

Г. Эрдэм номтой цэцнээс
Эд хөрөнгөтэй тэнэг доор

Дууссан:онсарөдөр

Холбоо үг

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Үгс өөр хоорондоо нөхцөлөөр болон үндсээрээ шууд холбогдон холбоо үг бүтээнэ. Ж нь: ах, шугам гэсэн хоёр үг харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр холбогдож, “ахын шугам” гэсэн холбоо үг бүтэж байна. Харин зузаан, ном гэсэн хоёр үг ямар нэг нөхцөлгүйгээр шууд холбогдож “зузаан ном” гэсэн холбоо үгийг бүтээж байна. Ийм холбоо үгийг үндсээр холбогдсон холбоо үг гэнэ.

Дасгал 22. Холбоо үгийн үүргийг ойлгоорой.

Алхам 1. Үгсийг зөв байрлуулан, өгүүлбэр бүтээгээрэй.

Үгс: урамшуулж, өдөр, өөрийгөө, бай, бүр

Өгүүлбэр:

Үгс: далны, цээрлэнэ, илэхийг, ганцаараа, хуулгыг

Өгүүлбэр:

Үгс: энэ, дуу эхийн, уяхан, хамгийн, хорвоод, бүүвэйн

Өгүүлбэр:

Үгс: үнэн, бай, бусдад, сэтгэлээсээ, баярлаж

Өгүүлбэр:

.....
 Үгс: : Аажуухан, өдрийн, наран, улаан, говьд, зуны, урт том, жаргалаа.

Өгүүлбэр
Алхам 2. Цэгийн оронд тохирох нөхцөл нөхөж, өгүүлбэрийг гүйцээгээрэй.

Хурдаа хассан нь

Багш: - Хүү минь яагаад хичээл.....ээ хоцор..... бэ?

Хүү: - Зам..... хажууг..... тэмдэг бол..... хоцорчихлоо.

Багш: - Зам..... хажууг..... тэмдэг чи..... хоцор.....д ямар буруу..... юм бэ?

Хүү: - Сургуул..... бүс! Хурдаа хас..... уу гэ..... бай..... шүү дээ.

Алхам 3: Дараах өгүүлбэрийн доторх үгсийн холбоог зурж тэмдэглээрэй

Үнхэлцээ хагартал айсан нь

Хүү: - Оливын тосыг юугаар хийдэг юм бэ? Ээж ээ!

Ээж: -Оливоор л хийнэ.

Хүү: - Тэгвэл хүүхдийн тосыг юугаар хийдэг юм бэ? Яана аа!!

Алхам 4. Өгүүлбэр доторх үгсийн холбоог тайлбарлаарай.

Хүү: - Өвөө та шүдтэй юу?

Өвөө: - Байхгүй.

Хүү: - Аан, та тэгвэл миний бэлгийг хадгалж байгаарай. Би гадаа тоглож байгаад ирье.

1. Өгүүлбэр бүтээж буй үгсэд асуулт тавиарай.	Хэн? Юутай юу? Та шүдтэй юу?
2. Холбоо үгээр задалж бичээрэй.	та шүдтэй, шүдтэй юу
3. Ямар хэрэглүүрээр холбогдсоныг тайлбарлаарай.	“Та шүдтэй” гэсэн холбоо үг нь нэрлэхийн тийн ялгалын тэг нөхцөлөөр холбогдож, холбоо үг бүтээж байна. Шүдтэй юу” хэмээх холбоо үг нь хамтрахын тийн ялгалын –тай нөхцөлөөр холбогдож, холбоо үг бүтээж байна.

1. Өгүүлбэр бүтээж буй үгсэд асуулт тавиарай.	1. 2. Та миний бэлгийг хадгалж байгаарай.
1. Холбоо үгээр задалж бичээрэй.	1. 2.
1. Ямар хэрэглүүрээр холбогдсоныг тайлбарлаарай.	1.

Алхам 5. Дараах холбоо үгсээр өгүүлбэр бүтээгээрэй

Зүүдэлсэн нь

Хүү маань босоод, өглөө босоод, би зүүдэлсэн, урд шөнө, урд шөнө зүүдэлсэн, зүүдэлсэн гээд, ээждээ ярьж, ярьж өгч байна.

.....
.....
.....

Тэгэхээр нь асуусан чинь, үргэлжлүүлээд асуусан чинь, “ Та өөрөө, та өөрөө тэнд байсан, байсан шүү дээ.

.....
.....
.....

Өөрөө байсан, байсан байж, надаас асуугаад,” гэж хэллээ. Гэр дүүрэн, дүүрэн инээд, инээд болж, болж билээ.

.....
.....
.....

Дууссан:онсарөдөр

Цөм өгүүлбэр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Өгүүлбэрийг бүтцээр нь энгийн ба нийлмэл өгүүлбэр гэж ангилна. Үйл үгийн тоогоор нь энгийн ба нийлмэл өгүүлбэрийг ялгана. Өгүүлбэрийн цөм бүтцийг бүрдүүлэгч өгүүлэгдэхүүн (хэн, юу), шууд тусагдахуун (хэнийг, юуг), өгүүлэхүүн (яав, яасан,) гишүүдийг гол гишүүд гэнэ. Тусгай таних тэмдгээр гишүүдийн доогуур нь зурна. Гол гишүүдээс бүтсэн өгүүлбэрийг цөм өгүүлбэр гэнэ.

Дасгал 23. Өгүүлбэрийг бүтцээр нь ялган таниарай.**Алхам 1. Хоёр хэсэг өгүүлбэрийн ялгааг олоорой. Зөв харгалзуулна уу.**

- | | |
|--|--|
| <p>а. Сумын төвийн байшингууд цуурайтна. Сургууль цэцэрлэг эл хуль болно. Сумын улаан булангийн үүдэнд сар сар мотор дуугарна</p> <p>б. Яав, машин явахаар сум доргих шиг чимээ гарна. Нугас цуурга гажсан сэнсрээ модон хаалга салхинаа савлана. Ирэх зуны явдлыг зөгнөж эмгэд гаднаа нарлана. Илүү гэр их гэрийн хооронд явж энэ тэрхнийг хийнэ. Тэгээд гэртээ орж тээрмийн буудай хуурна.</p> | <p>1. Өгүүлбэр тус бүр нь 2-оос дээш үйл үгтэй нийлмэл өгүүлбэр</p> <p>2. Өгүүлбэр бүр нь зөвхөн нэг үйл үгтэй энгийн өгүүлбэр</p> |
|--|--|

Алхам 2. Алхам 1-ийн “б” хэсэгт байгаа өгүүлбэрүүдийг үйл үгийн тоогоор нь энгийн өгүүлбэр болгож задлаарай.

Нийлмэл өгүүлбэр: Яав, машин явахаар сум доргих шиг чимээ гарна.
Энгийн өгүүлбэр: Яав, машин явна. Сум доргих шиг чимээ гарна.

Нийлмэл өгүүлбэр: Нугас цуурга гажсан сэнсрээ модон хаалга салхинаа савлана.
Энгийн өгүүлбэр:

Нийлмэл өгүүлбэр: Ирэх зуны явдлыг зөгнөж эмгэд гаднаа нарлана.
Энгийн өгүүлбэр:

Нийлмэл өгүүлбэр: Илүү гэр их гэрийн хооронд явж энэ тэрхнийг хийнэ.
Энгийн өгүүлбэр:

Нийлмэл өгүүлбэр: Тэгээд гэртээ орж тээрмийн буудай хуурна.
Энгийн өгүүлбэр:

Дасгал 24. Өгүүлбэрийн гол гишүүдийг асуултаар ялган таниарай.**Алхам 1. Өгүүлбэр дэх үгсэд асуулт тавиарай.**

Юуны? Юуны? Юу? Яана?

Сумын төвийн байшингууд цуурайтна. Сургууль цэцэрлэг эл хуль болно. Сумын улаан булангийн үүдэнд сар сар мотор дуугарна. Ирэх зуны явдлыг зөгнөнө. Эмгэд гаднаа нарлана.

Алхам 2. Өгүүлбэрүүдээс гол гишүүдийг ялган, доогуур нь зураарай.

Өгүүлбэр	Өгүүлбэрийн цөм бүтэц		
	хэн/юу?	хэнийг/юуг?	яав? яана?
Сумын төвийн байшингууд цуурайтна.	Байшингууд		цуурайтна.
Сургууль цэцэрлэг эл хуль болно.	Сургууль		эл хуль болно.
Сумын улаан булангийн үүдэнд сар сар мотор дуугарна.			
Эмгэд ирэх зуны явдлыг зөгнөнө.			
Эмгэд гаднаа нарлана.			






Алхам 3. Өмнөх алхамд байгаа хүснэгтээ ажиглаж, өгүүлбэрийн гол гишүүдийн онцлогийг тайлбарлаарай. Хүснэгтийг гүйцээнэ үү.

	өгүүлэгдэхүүн	шууд тусагдахуун	өгүүлэхүүн
Илрэх үгийн аймаг	жинхэнэ нэр		
Утга	үйлийн эзэн	Үйлэнд шууд өртөгч	Үйл хөдлөл
Асуулт	хэн? юу?		
Хувилал	нэрлэхийн тийн ялгал		
Тэмдэг	-----	=====

Алхам 4. Цөм өгүүлбэрийн ангиллын тухай ойлголтыг дэвтэртээ бичиж аваарай.

Гол гишүүдээс бүтсэн өгүүлбэрүүдийг цөм өгүүлбэр гэнэ. Цөм өгүүлбэр нь тусах үйл үгтэй байвал 3 бүрэлдэхүүнт, эс тусах үйл үгтэй бол 2 бүрэлдэхүүнт өгүүлбэр гэнэ. Өмнөө хэнийг, юуг гэсэн асуултад хариулагдах үгийг захирч байгаа үйл үгийг тусах (яриаг **сонсох**, номыг **унших**), өмнөө заахын тийн ялгалтай нэр үгийг захирч чадахгүй байвал эс тусах (гадаа **суух**, гэрээс **ирэх**) үйл үг гэнэ.

Алхам 5. Дараах зургаар цөм өгүүлбэр зохиогоод, бүрэлдэхүүнийг тодорхойлоорой.

		
3		2
Хүүхдүүд (хэн) бөмбөг (юуг) тоглож байна. (яаж байна)		Тэд (хэн) уралдав. (яав)
		

Дууссан:онсарөдөр

Цөм бус өгүүлбэр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Өгүүлбэрийн гишүүдийг гол (өгүүлэгдэхүүн, шууд тусагдахуун, өгүүлэхүүн) ба дэлгэрүүлэгч (тодотгол, шууд бус тусагдахуун, байц) гэж хоёр ангилна. Өгүүлбэрийн цөм бүтцийг тодотгол, шууд бус тусагдахуун, байц гишүүнээр дэлгэрүүлнэ. Эдгээрийг дэлгэрүүлэгч гишүүд гэнэ. Тодотгол гишүүн (хэний, юуны, ямар, аль, хэрхэн, хэд хэчнээн), шууд бус тусагдахуун (хэнд, юунд, хэнээс, юунаас, хэнээр, юугаар, хэнтэй, юутай), байц (хаана, хэзээ, хаашаа, хаагуур,) гэсэн асуултад тус тус хариулагдана.

Дасгал 25. Дэлгэрэнгүй, цөм бус өгүүлбэрийг ялган таниарай.

Алхам 1. Цөм өгүүлбэрийг өгсөн асуултад хариулагдах үгээр дэлгэрүүлээрэй.



Бат гарав.

Хэзээ? Хэнтэй?
Хаашаа?

.....
.....
.....



Хоёул цасан хүн хийв.

Юунаас? Ямар?

Хоёул өөрдөөсөө
том цасан хүн
хийв.



Тэд хамар, гар, нүд хийж дуусгав.

Юунд?

.....
.....
.....



Нар гарав.
Цасан хүн хайлав.

Хэзээ? Ямар?

.....
.....
.....

Алхам 2. Дараах асуултад хариулагдах үгсийг нөхөж, өгүүлбэрийг гүйцээгээрэй

номин ногоон, хөхөөн, тунгалаг, талын, хөгжилтэй, жараахайтай, өдөржин, бэл хормойгоор, бүгтхэн, булгийн, горхины, уяан, дээрх

- a. Ямар? _____ уулын юугаар? _____ манан будан хөшилдөнө.
- b. Юуны? _____ дүү хэрхэн? _____ дохиолно.
- c. Ямар? _____ юуны? _____ ус харгиа боргио үүсгэнэ.
- d. Юуны? _____ энгүйг хэрхэн? _____ хээлнэ.
- e. Багацүүл _____ Юуны? _____ Юутай? _____ Хэзээ? _____ хөөцөлдөнө.
- f. Юуны? _____ Хаана? _____ морьд хамраа сарталзүүлнэ.

Дууссан:онсарөдөр

Алхам 3. Дараах өгүүлбэрийг гишүүдээр зурж, тэмдэглээрэй.

- Буурал дэлтийн минь уяа сойлгыг хүмүүс магтана.
- Аав гаансныхаа соруулаар оочны сахлаа оролдоно.
- Эмгэд энэ зуны сайхныг ярилцана.
- Ирээдүй цагийн өнгийг хөгшид шинжинэ.
- Гэрийн хаяанд тэд нарлана.
- Ээж, эгч нар аарц шүүнэ.
- Тэр ааруул зүсэж, дэлгэцэн дээр өрнө.

Гишүүдээр зурахдаа “Агуулгын товч тайлбар” гэсэн хэсэгт байгаа онолын ойлголтыг ашиглаж хийгээрэй.

Алхам 4. Дараах хүснэгтэд өгсөн онолын ойлголтыг ашиглан, өгүүлбэрийн гишүүнийг дэлгэрэнгүй тайлбарлаарай.

Өгүүлбэрийн гишүүд		Утга	Асуулт	Илрэх үгийн аймаг	Холбогдох үг
Гол гишүүд	Өгүүлэгдэхүүн	үйлийн эзэн	хэн, юу	жинхэнэ нэр	үйл үгтэй
	Шууд тусагдахуун	үйлэнд шууд өртөгч юм	хэнийг, юуг	жинхэнэ нэр	үйл үгтэй
	Өгүүлэхүүн	үйл хөдлөл	яадаг яасан, яав, яалаа,...	үйл үг	жинхэнэ нэртэй үйл үгтэй
Дэлгэрүүлэгч гишүүд	Тодотгол	тоо, шинж, хамаа харьяа, дүр байдал	хэд, хэчнээн, ямар, аль, хэний юуны, хэрхэн	тооны нэр тэмдэг нэр жинхэнэ нэр дүрслэх дуурайх үг	жинхэнэ нэр үйл үгтэй
	Шууд бус тусагдахуун	үйлэнд шууд бусаар өртөгч	хэнд, юунд, хэнээс, юунаас, хэнээр, юугаар, хэнтэй, юутай	жинхэнэ нэр	үйл үгтэй
	Байц	орон байр, зүг чиг	хэзээ, хаана, хаашаа, хаагуур	орон цагийн нэр	үйл үгтэй

Ажиллах өгүүлбэр. Довын энгэрт агь нүдэлжээ.

- “Довын” хэмээх харьяаны утгатай жинхэнэ нэр нь юуны гэсэн асуултад хариулагдан, харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр “энгэрт” гэдэг үгтэй холбогдон тодотгол гишүүн болжээ.
- энгэрт
- агь
- нүдэлжээ

Дууссан:онсарөдөр

Алхам 3. Дараах өгүүлбэрийг гишүүдээр зурж, тэмдэглээрэй.

- Буурал дэлтийн минь уяа сойлгыг хүмүүс магтана.
- Аав гаансныхаа соруулаар оочны сахлаа оролдоно.
- Эмгэд энэ зуны сайхныг ярилцана.
- Ирээдүй цагийн өнгийг хөгшид шинжинэ.
- Гэрийн хаяанд тэд нарлана.
- Ээж, эгч нар аарц шүүнэ.
- Тэр ааруул зүсэж, дэлгэцэн дээр өрнө.

Гишүүдээр зурахдаа “Агуулгын товч тайлбар” гэсэн хэсэгт байгаа онолын ойлголтыг ашиглаж хийгээрэй.

Алхам 4. Дараах хүснэгтэд өгсөн онолын ойлголтыг ашиглан, өгүүлбэрийн гишүүнийг дэлгэрэнгүй тайлбарлаарай.

Өгүүлбэрийн гишүүд		Утга	Асуулт	Илрэх үгийн аймаг	Холбогдох үг
Гол гишүүд	Өгүүлэгдэхүүн	үйлийн эзэн	хэн, юу	жинхэнэ нэр	үйл үгтэй
	Шууд тусагдахуун	үйлэнд шууд өртөгч юм	хэнийг, юуг	жинхэнэ нэр	үйл үгтэй
	Өгүүлэхүүн	үйл хөдлөл	яадаг яасан, яав, яалаа,...	үйл үг	жинхэнэ нэртэй үйл үгтэй
Дэлгэрүүлэгч гишүүд	Тодотгол	тоо, шинж, хамаа харьяа, дүр байдал	хэд, хэчнээн, ямар, аль, хэний юуны, хэрхэн	тооны нэр тэмдэг нэр жинхэнэ нэр дүрслэх дуурайх үг	жинхэнэ нэр үйл үгтэй
	Шууд бус тусагдахуун	үйлэнд шууд бусаар өртөгч	хэнд, юунд, хэнээс, юунаас, хэнээр, юугаар, хэнтэй, юутай	жинхэнэ нэр	үйл үгтэй
	Байц	орон байр, зүг чиг	хэзээ, хаана, хаашаа, хаагуур	орон цагийн нэр	үйл үгтэй

Ажиллах өгүүлбэр. Довын энгэрт агь нүдэлжээ.

- “Довын” хэмээх харьяаны утгатай жинхэнэ нэр нь юуны гэсэн асуултад хариулагдан, харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр “энгэрт” гэдэг үгтэй холбогдон тодотгол гишүүн болжээ.
- энгэрт
- агь
- нүдэлжээ

Дууссан:онсарөдөр

Нэгж хичээлийн үнэлгээ

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 26. Дараах даалгавруудыг гүйцэтгээрэй.

1. Дараах холбоо үгсийг зөв байрлуулан өгүүлбэр бүтээгээрэй.

Холбоо үг: довын энгэр, энгэрт нүдэлж, агь нүдэлж, нөмөр газарт, газарт нүдэлсэн, хөх яргуй, яргуй нүдэлсэн, нүдэлсэн цаг.

Өгүүлбэр нь:

.....

Холбоо үг: зуны өглөө, нэгэн өглөө, урт сайхан, сайхан замын, замын дэргэд, дэргэд буулаа, хос тогоруу, хос тогоруу ирж, ирж буулаа.

Өгүүлбэр нь:

.....

2. Дараах өгүүлбэрийг холбоо үгээр задлаарай.

Өгүүлбэр: Тэртээ нүдний үзүүрт уул, үүл уулзан золгоно.

Холбоо үг:

.....

3. “Үүрийн цагаан гэгээ тэнүүн талд туслаа.” гэсэн өгүүлбэрийн цөм бүтцийг олоорой.

A. Цагаан гэгээ талд туслаа. C. Цагаан гэгээ туслаа.

B. Гэгээ талд туслаа D. Гэгээ туслаа.

4. Дараах өгүүлбэрүүдээс гол гишүүдийг олж зураарай.

Ажиллах өгүүлбэр:

- Тэр хоёр хаврын хатуу улирлыг эсэн мэнд өнгөрөөв.
- Хос тогоруу зуны сайхан цагийн босгыг алхав.
- Орхоны их тал дээр ногооны цэнхэр униар татлаа.
- Хоньчин хүүхэд чулуугаар хот гэр барилаа
- Намрын бэлчээрийн соргог ногоонд хоньд цаджээ.

5. Дараах цөм өгүүлбэрийг дэлгэрүүлэгч гишүүдээр дэлгэрүүлж, цөм бус өгүүлбэр зохиогоорой.

- Болжмор жиргэнэ.
- Одод анивалзав.
- Өдөр боллоо.
- Тэр өдрийг хүлээнэ.
- Хүмүүс тэднийг гаргав.

Дууссан:онсарөдөр